



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Empowered lives.  
Resilient nations.

**МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ  
(2018-2025)  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭ  
(Тайлан IV)**

Улаанбаатар хот  
2018 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Empowered lives.  
Resilient nations.

# МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ (2018-2025) ХӨГЖЛИЙН ХҮРЭЭ (Тайлан IV)

Улаанбаатар хот  
2018 он

## **АЖЛЫН БАГ**

### **Судалгааг удирдан зохион байгуулагчид**

Б.Баярсайхан, Үндэсний хөгжлийн газрын дарга, Докторант  
Ж.Должинсүрэн, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн газрын дарга, Докторант  
С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Үндэсний  
хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд

### **Судлаачид**

ШУ-ны доктор А.Даваасүрэн (Багийн ахлагч)  
Доктор Б.Батмөнх  
Доктор О.Бат-Эрдэнэ  
Магистр Д.Лхагвадорж

### **Хянан тохиолдуулагч Доктор Б.Батхишиг**

Энэхүү судалгааны ажлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн техникийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Үндэсний хөгжлийн газрын судалгааны ажлууд нь хөгжлийн бодлогын чиглэлээр тулгамдаж буй чухал асуудлуудыг хөндлөнгийн судалгаан дээр тулгуурлан хөнддөг тул судалгааны санал, дүгнэлт нь тус газрын албан ёсны байр суурийг зайлшгүй илэрхийлэх албагүй болно.

Илтгэлийг ашгийн бус зорилгоор хуулбарлах, олшруулж тараахыг зөвшөөрнө.

## ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, түүний өнөөгийн байдал болон алдаа дутагдал, цаашдын сургамжийн талаар, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдааг үнэлэх, бодлогын тэргүүлэх чиглэл, үзүүлэлтийн хүрэх түвшинг тодорхойлох, төлөвлөлтийн арга зүй, түүнчлэн 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн хүрээ зэргийг тодорхойлсон таван боть тайланг та бүхэнд толилуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн хугацаанд, Монгол Улс зах зээлийн шилжилтийг туулж, ардчилсан тогтолцоог нутагшуулсан 28 жилийн хугацаанд эдийн засаг өсч, хөгжлийн тодорхой хэд хэдэн үзүүлэлтүүдээрээ дэлхийн дундаж

түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтаж, уул уурхай, газар тариалан, барилга, худалдаа үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрсэн боловч эдийн засгийн төрөлжилт, үйлдвэржилт, засаглал, дэд бүтэц, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарын хөгжилд бэрхшээлүүд тулгарсан хэвээр байгаа билээ.

1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш урт хугацааны хөгжлийн хэд хэдэн стратегийг боловсруулж байсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрүүд нь бодит байдалтай нийцгүй, залгамж чанаргүй, төсөвтэй уялдаагүй байсаар иржээ. Үүний зэрэгцээ дөрвөн жил тутам зохион байгуулагддаг сонгуулийн циклийг даган Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгддөг, мөн бодлогын баримт бичгүүд хэт олширсон тэдгээрийн хоорондын уялдаа хангагддаггүй зэргээс үүдэн хөгжлийн бодлогын баримт бичгүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Үүний улмаас, Монгол Улсын хөгжил тогтворгүй, эмзэг, баялгийн тэгш бус хуваарилалт нэмэгдсэн, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, нийтээрээ хөгжлийн талаарх нэгдсэн ойлголтгүй болсон гэх мэт олон сөрөг үр дагаврууд бий болжээ. Энэ бүх хугацаанд хөгжлийн талаарх олон баримт бичиг, бодлогууд боловсруулж батлуулсан боловч нийгэмд нийтээрээ хүлээн зөвшөөрөгдөхүйц бодит өөрчлөлт, үр дүнд хүрэхгүй байгаа нь улсын тогтвортой хөгжлийн нэгдсэн ойлголт, бодлого, зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм, хууль эрх зүйн орчин дутагдалтай байсны илрэл юм.

Үүний мөрөөр, Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын өнөөгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог шинэчлэх, шинжлэх ухаан, тооцоо судалгаанд үндэслэн харилцан уялдаа бүхий бодлого, стратеги боловсруулдаг байх, түүнд чиглэсэн чадавхыг сайжруулах зорилгоор энэхүү таван



боть тайланг боловсрууллаа. Энэхүү тайланд судалсан арга зүйг Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй олон улсын сайн туршлагад үндэслэн, манай орны салбар бүрийн төрийн болон төрийн бус байгууллагын, мэргэжлийн судлаачдын олон талын төлөөллийн үнэтэй санал, зөвлөмжийг тусган боловсруулсан. Энэхүү тайланд тусгагдсан арга зүй, санал зөвлөмжүүдийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэх бөгөөд цаашид Монгол Улсад цэгцтэй, уялдаатай, залгамж чанар бүхий бодлого, хөтөлбөр, механизмуудтай, харилцан уялдаа бүхий зохицуулалттай төрийн институцтэй, зах зээлийн эдийн засагт нийцсэн төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх бидний хүчин чармайлт биелэлээ олно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү таван боть тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар ханган бүх талаар дэмжин ажилласан ҮХГ-ын дарга Б.Баярсайхан танд гүн талархлаа илэрхийлье. Мөн түүнчлэн, тайланг боловсруулахад нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргаж ажилласан судлаачдийн баг болон тайланг боловсруулахад бүхий л талаар оролцон хөдөлмөр зүтгэлээ гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд болох С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Р.Сийлэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Түүнчлэн, манай улсын хөгжлийн төлөвлөлтийг сайжруулахад үнэ цэнэтэй дэмжлэг туслалцаа өгч хамтран ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Монгол дахь суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн суурин төлөөлөгч хадагтай Беате Транкманн, НҮБХХ-ийн орлогч суурин төлөөлөгч хадагтай Даниела Гаспарикова болон НҮБХХ-ийн хамт олонд гүн талархалаа илэрхийлье.

**Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга  
Жамбалын Должинсүрэн**

# АГУУЛГА

## ӨМНӨХ ҮГ

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

## БҮЛЭГ 1. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛСОН ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ

1.1. Дунд хугацааны төлөвлөлт хийх урьдчилсан нөхцөл	1
1.2. Дунд хугацааны хөгжлийн хүрээг тодорхойлсон арга зүй	1
1.3. Эдийн засгийн нөөцийн болон хөгжлийн гадаад орчны шинжилгээ	3
1.3.1. Эдийн засгийн нөөцийн шинжилгээ	3
1.3.1.1. Хүн ам, хөдөлмөрийн нөөц	3
1.3.1.2. Байгалийн нөөц баялаг	5
1.3.1.3. Эдийн засгийн нийт болон тодорхой төрлийн нөөц	6
1.3.2. Монгол Улсын хөгжлийн гадаад орчны шинжилгээ	8
1.4. Нөхцөл байдлын шинжилгээнээс гарсан ерөнхий дүгнэлт	12

## БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНИЙ 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

2.1. 2018-2025 оны макро эдийн засгийн ерөнхий хүрээний төсөөлөл	15
2.1.1. ДНБ-ий 2018-2025 оны төсөөлөл	15
2.1.2. Нэг хүн амд ногдох Үндэсний нийт орлого	20
2.1.3. ДНБ-ий салбарын бүтцийн төсөөлөл	21
2.1.4. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтцийн төсөөлөл	26
2.1.5. Инфляцын төсөөлөл	28
2.1.6. Хөрөнгө оруулалтын 2018-2025 оны төсөөлөл	31
2.1.7. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төсөөлөл	32
2.1.8. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт	37
2.2. Сонгосон салбарын 2018-2025 оны хөгжлийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл, урьдчилсан тооцоо	38
2.2.1. Эрчим хүчний салбар	39
2.2.2. Хөдөө аж ахуйн салбар	41
2.2.2.1. Мал аж ахуй	44
2.2.2.2. Газар тариалан	45

2.2.3. Уул уурхайн салбар	45
<b>БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНИЙ 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ</b>	
3.1. Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд	49
3.2. Ядуурлыг бууруулах зорилтын төсөөлөл	52
3.3. Хүний хөгжлийн үзүүлэлтүүд	52
3.4. Боловсролын салбарын зарим үзүүлэлт	54
3.5. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлт	56
3.5.1. Хүн амын дундаж наслалт	56
3.5.2. Эхийн эндэгдэл	57
3.5.3. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	58
3.5.4. Нялхсын эндэгдэл	58
3.5.5. Зарим төрлийн өвчнөөс шалтгаалсан нас баралтын талаарх төсөөлөл	59
<b>БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ</b>	
4.1. Ногоон хөгжил	61
4.2. Хүлэмжийн хийн ялгарал	61
4.3. Ойгоор бүрхэгдсэн талбай	63
4.4. Байгаль орчны бусад үзүүлэлтүүд	64
<b>САНАЛ, ДҮГНЭЛТ</b>	
5.1. Ерөнхий дүгнэлт	67
5.2. Дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн боломж, боллоцгоо	68
5.3. Санал	69
<b>НОМ ЗҮЙ</b>	71

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын хүн амын тоо	3
Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн 2010-2017 оны үндсэн үзүүлэлтүүд	4
Хүснэгт 3. Монгол улсын ашигт малтмалын нөөцийн зах зээлийн үнэлгээ	5
Хүснэгт 4. Макро эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ ба бүтэц	6
Хүснэгт 5. Монгол Улсын газрын нэгдмэл сан	7
Хүснэгт 6. 2010-2017 оны Монгол Улсын гадаад худалдааны эргэлт	8
Хүснэгт 7. Монгол Улсын гадаад худалдаанд хөрш орнуудын эзлэх хувийн жин	9
Хүснэгт 8. Монгол Улсын гадаад худалдаанд дэлхийн томоохон улсуудын эзлэх хувийн жин	10
Хүснэгт 9. ОУВС-аас гаргасан Дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлтийн таамаглал	11
Хүснэгт 10. Дэлхийн зах зээл дээрх манай улсын экспортын зарим барааны үнийн таамаглал	11
Хүснэгт 11. ДНБ-ий дефляторын өсөлт	20
Хүснэгт 12. Монгол Улсын нэг хүн амд ногдох Үндэсний нийт орлого	20
Хүснэгт 13. ДНБ-ий 2018-2025 оны салбарын задаргааны төсөөлөл	22
Хүснэгт 14. ДНБ-ий 2018-2025 оны салбарын бүтцийн төсөөлөл	23
Хүснэгт 15. ДНБ-ий 2018-2025 оны салбарын задаргааны төсөөлөл	25
Хүснэгт 16. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, дээд хувилбар	26
Хүснэгт 17. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, дунд хувилбар	27
Хүснэгт 18. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, доод хувилбар	27
Хүснэгт 19. Эдийн засгийн макро түвшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийн төсөөлөл	28
Хүснэгт 20. Хөрөнгө оруулалтын 2018-2025 оны төсөөлөл	32
Хүснэгт 21. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын хэмжээ	34
Хүснэгт 22. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн 2018-2025 оны түвшний төсөөлөл	37
Хүснэгт 23. Эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний доороос дээш чиглэсэн төсөөлөл	40
Хүснэгт 24. Эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл	40
Хүснэгт 25. Эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэл	41
Хүснэгт 26. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын нийт үйлдвэрлэл	42
Хүснэгт 27. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл	43
Хүснэгт 28. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл	43
Хүснэгт 29. Мал аж ахуйн нийт үйлдвэрлэл	44
Хүснэгт 30. Халдварт өвчин гарсан сум	44
Хүснэгт 31. Мал аж ахуйн нийт үйлдвэрлэлийн төсөөлөл	44



Хүснэгт 32. Газар тариалангийн нийт үйлдвэрлэл	45
Хүснэгт 33. Газар тариалангийн нийт үйлдвэрлэлийн төсөөлөл	45
Хүснэгт 34. Уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүний төсөөлөл	47
Хүснэгт 35. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл	47
Хүснэгт 36. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл	48
Хүснэгт 37. Хүн амын тооны төсөөлөл	49
Хүснэгт 38. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөлөл	50
Хүснэгт 39. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөлөл	50
Хүснэгт 40. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны прогноз	51
Хүснэгт 41. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс	53
Хүснэгт 42. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тооны төсөөлөл	55
Хүснэгт 43. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	55
Хүснэгт 44. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тооны төсөөлөл	55
Хүснэгт 45. Хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулах хувь	56
Хүснэгт 46. Анги дүүргэлтийн улсын дундаж тооны төсөөлөл	56
Хүснэгт 47. Хүн амын дундаж наслалтын өмнөх онуудын түвшин	56
Хүснэгт 48. Хүн амын дундаж наслалтын 2018-2025 оны төсөөлөл	57
Хүснэгт 49. 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн төсөөлөл	57
Хүснэгт 50. 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	58
Хүснэгт 51. 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн төсөөлөл	58
Хүснэгт 52. Нялхсын эндэгдлийн тооны төсөөлөл	59
Хүснэгт 53. Зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралтын тооны төсөөлөл	59
Хүснэгт 54. Хавдраас шалтгаалсан нас баралтын тооны төсөөлөл	60
Хүснэгт 55. Нийт хүлэмжийн хийн шингээлт, ялгарал	61
Хүснэгт 56. Хүлэмжийн хийн ялгарал	62
Хүснэгт 57. Ойгоор бүрхэгдсэн газар нутгийн талбайн эзлэх хувь	63
Хүснэгт 58. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	64
Хүснэгт 59. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	64
Хүснэгт 60. Улсын тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээний 2025 он хүртэлх төсөөлөл	64
Хүснэгт 61. Байгаль орчны зарим үзүүлэлтийн 2025 он хүртэлх төсөөлөл	65

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ	10
Зураг 2. ДНБ-ий жил бүрийн өсөлтийн хувь	13
Зураг 3. Олон улсын байгууллагууд болон Сангийн яамнаас Монгол Улсын ДНБ-ий ойрын жилүүдийн өсөлтийн талаар гаргасан таамаглал	15
Зураг 4. ДНБ-ий суурь онтой харьцуулсан өсөлт, цаашдын чиг хандлага	16
Зураг 5. ДНБ-ий 2018-2025 оны жил бүрийн өсөлтийн төсөөлөл	17
Зураг 6. ДНБ-ий суурь онтой харьцуулсан өсөлт	18
Зураг 7. ДНБ-ий 2018-2025 онд хүрэх түвшин	19
Зураг 8. ДНБ-ий дефляторын өсөлтийн тренд	19
Зураг 9. ДНБ, 2017-2025 оны үнээр, тэрбум төгрөг	20
Зураг 10. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО	21
Зураг 11. Инфляцийн 2000-2017 оны жил бүрийн өсөлтийн хувь	28
Зураг 12. ДНБ болон инфляцын суурь 2000 онтой харцуулсан өсөлт	29
Зураг 13. ДНБ болон инфляцын корреляцийн хамаарлын цэгэн тархалт	29
Зураг 14. Инфляцын өсөлтийн 2000-2017 оны гүйцэтгэл болон 2018-2025 оны төсөөлөл	30
Зураг 15. 2010-2017 оны инфляцийн жил бүрийн өсөлтийн гүйцэтгэл болон 2018-2025 оны төсөөлөл	31
Зураг 16. Хөрөнгө оруулалт болон ДНБ-ий хамаарлын цэгэн тархалт	31
Зураг 17. ДНБ болон нэгдсэн төсвийн зарлагын жил бүрийн өсөлт	33
Зураг 18. ДНБ болон нэгдсэн төсвийн зарлагын суурь онтой харьцуулсан байдал	33
Зураг 19. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, цаашдын чиг хандлага	34
Зураг 20. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын хамаарал	35
Зураг 21. ДНБ болон нэгдсэн төсвийн орлогын хамаарал	35
Зураг 22. Улсын нэгдсэн төсвийн 2017-2025 оны орлого, зарлага, тэнцэл	36
Зураг 23. ДНБ-д нэгдсэн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь	37
Зураг 24. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж	38
Зураг 25. Ядуурлыг 2018-2025 онд бууруулах төсөөлөл	52
Зураг 26. Хүний хөгжлийн индекс	53
Зураг 27. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс	53
Зураг 28. Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн 2018-2025 оны таамаглал	54
Зураг 29. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	54
Зураг 30. 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	57
Зураг 31. Нялхсын эндэгдлийн түвшин	58
Зураг 32. Зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралт	59
Зураг 33. 100 мянган хүн амд ногдох хавдраас шалтгаалсан нас баралт	60
Зураг 34. Хүлэмжийн хийн ялгарлын цэвэр өсөлт, бууралт	62
Зураг 35. Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь	63

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУТХҮБ-2030 - Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

ДБ - Дэлхийн Банк

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

ҮНО - Үндэсний нийт орлого

ҮХГ - Үндэсний хөгжлийн газар

ХБТГ- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

ХАА - Хөдөө аж ахуй

МАА - Мал аж ахуй

ОХУ- Оросын Холбооны Улс

БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс

АНУ - Америкийн Нэгдсэн Улс

ОУВС - Олон Улсын Валютын сан

ЗХУ - Зөвлөлт Холбоот Улс

АМГТГ - Ашигт малтмал, газрын тосны газар

ГЗБГЗЗГ - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар

ХНБ - Холбооны Нөөцийн банк

АХБ - Азийн хөгжлийн банк

ХХИ - Хүний хөгжлийн индекс

ЕТЗ - Ерөнхий тэнцвэрийн загвар

ТХЗХЗЗ - Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд зориулсан загвар

## БҮЛЭГ 1. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛСОН ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ

### 1.1. Дунд хугацааны төлөвлөлт хийх урьдчилсан нөхцөл

Зүүн өмнөд Азийн орнууд, ялангуяа төлөвлөлтийн сайн тогтолцоотой, арвин их туршлагатай орнуудын жишээнээс харахад үндэсний хэмжээний дунд хугацааны иж бүрэн цогц төлөвлөлтийг эхлэхийн өмнө төлөвлөлтийг амжилттай хийх урьдчилсан бүх нөхцлийг бүрдүүлдэг байна. Үүнд, дараах үндсэн нөхцөлүүд нэн тэргүүнд хамаарна.

- Төлөвлөлтийн хууль эрх зүйн маш тодорхой орчин бүрдсэн байх ёстой;
- Хариуцлагатай, сайн засаглал бий болсон байх;
- Төлөвлөлтийн иж бүрэн институцийн тогтолцоо бэлэн байх;
- Төлөвлөлтийг хийх мэдлэг, чадвартай боловсон хүчин бэлтгэгдсэн байх;
- Төрийн албаны сахилга бат, хариуцлага өндөр түвшинд хүрсэн, удирдлагын дээд түвшний болон салбар дундын зохицуулах ажлын хэсгүүд байгуулагдсан байх;
- Хөгжлийн урт, дунд хугацааны алсын хараа, макро түвшний болон салбарын бодлого, тэргүүлэх зорилтууд тодорхойлогдсон байх шаардлагатай ажээ.

Дунд хугацааны хөгжлийн хүрээг тодорхойлох анхны оролдлогыг энэхүү судалгаагаар олон улсын сайн туршлагад суурилан, өөрсдийн боловсруулсан арга зүйг ашиглан, макро эдийн засгийн хүрээнд болон сонгосон цөөн салбарын үзүүлэлтээр хийснийг тэмдэглэж байна.

### 1.2. Дунд хугацааны хөгжлийн хүрээг тодорхойлсон арга зүй

1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлтийн социалист хэв маягийн загварыг өргөн ашигладаг байсныг та бид мэднэ. Социалист төлөвлөлт нь зах зээлийн эрэлтэд чиглэгдээгүй эдийн засгийн тооны өсөлтөд ихээхэн анхаардаг, өрөөсгөл талтай. Төлөвлөлтийн энэхүү арга хэлбэр, төлөвлөгөөний шинж төрх их өөр, хуучин Зөвлөлт Холбоот Улсын жишгээр “директивный” буюу удирдамжийн шинж төрхтэй төлөвлөлт байсан байна. Төлөвлөгөөг төрийн өмч ноёрхсон үйлдвэрийн газар, хамт олны зүгээс заавал биелүүлэх ёстой хатуу даалгавар гэж үзэж байсны зэрэгцээ дээрээс өгсөн төлөвлөгөөг биелүүлсэн байдлыг аливаа байгууллагын үйл ажиллагааг нь үнэлж дүгнэх гол шалгуур болгон ашигладаг байлаа. Энэ үед төлөвлөлтийн гол арга нь нормативын болон балансын арга байсныг тэр үед ажиллаж байсан хүмүүс өгүүлж байна.

Манай орны хувьд зах зээлийн шинэ нөхцөлд төлөвлөлтийг хийх арга туршлага хомс, энэ чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин алга байна. Төслийн баг жил гаруй хугацаанд олон улсын туршлагыг судалж, манай орны нөхцөлд дунд хугацааны төлөвлөлтийг хийх арга зүйг боловсруулж, түүнийг үндэслэн 2018-2025 оны эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх хөгжлийн хүрээг гаргалаа. Энэ хугацаанд төслийн багийн гишүүд ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (ХБТГ)-аас зохион байгуулсан Ерөнхий тэнцвэрийн загвар (ЕТЗ) ашиглан хэтийн тооцоог хийх, олон хувилбараар бодлогын шок өгч, симуляци хийх талаар гадаадын зөвлөх мэргэжилтнүүдийн хийсэн



сургалтад хамрагдсан. Энэхүү загварыг тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд зориулан SDGSIM (Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд зориулсан загвар буюу Ерөнхий тэнцвэрийн динамик хувилбар) болон Монгол Улсын 2015 оны салбар хоорондын тэнцлээс боловсруулагддаг нийгмийн тооцооны матрицад үндэслэн боловсруулав. Мөн төслийн багийнхан ҮХГ-ын ХБТГ-аас зохион байгуулсан “Сценари төлөвлөлт хийх” арга зүй сургалтад оролцож мэдлэг, мэдээлэл олж авсан.

Төлөвлөлтийг сайн хийдэг орнуудын туршлагаас харахад үндэсний хэмжээний иж бүрэн цогц төлөвлөлт нь дээрээс доош чиглэсэн макро төлөвлөлт, доороос дээш чиглэсэн яам, агентлаг, орон нутгийн түвшинд хийгддэг микро төлөвлөлт гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэж байна. Дээрээс болон доороос төлөвлөх аргын гол давуу тал нь макро түвшний бодлогын зорилтууд, түвшний хүрээг мезо (салбар болон орон нутгийн түвшний) болон микро (аж ахуйн нэгж, байгууллагын түвшний) түвшний зорилтууд, үзүүлэлтүүдтэй нягт уялдуулах, тэдгээрийн хооронд материал, санхүүгийн нөөц болон хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилах боломжийг олгодогт оршдог.

Бид энэхүү ерөнхий арга зүйг ашиглан 2018-2025 оны макро эдийн засгийн ерөнхий хүрээг тогтоосон. Энэхүү хүрээг дараах үндсэн үзүүлэлтээр он болон хүрэх түвшингийн хамт тодорхойлсон. Үүнд:

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, улсын дүнгээр, салбараар, болон 2018-2025 оноор тодорхойлсон 3 хувилбартай төсөөлөл;
2. ДНБ-ий тооцоог эцсийн ашиглалтын элементүүдээр, тухайлбал, эцсийн хэрэглээ, хуримтлал, экспорт, импортын задаргаатайгаар оны үнийн төсөөлөл;
3. Нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого (ҮНО)-ын төсөөллийг (Дэлхийн Банкны атласын аргаар) ам.доллар;
4. Инфляцын түвшний 2018-2025 оны төсөөлөл;
5. Хөрөнгө оруулалтын 2018-2025 оны төсөөлөл;
6. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын төсөөллийг 2018-2025 оноор;
7. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн хүрэх түвшинг 2018-2025 оноор;
8. Хүн амын тоо, үүний дотор 15 болон түүнээс дээш хөдөлмөрийн насны хүн амын тоог Үндэсний статистикийн хорооны (ҮСХ) “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, 2017”-г үндэслэн 2017 оны хүн амын гүйцэтгэлээр тодотгосон төсөөлөл;
9. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт, тухайлбал ажиллагсдын тоо, ажилгүйчүүдийн тоо, ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлтийн болон ажилгүйдлийн хүрэх түвшин 2018-2025 онуудаар тус тус тооцов.

Макро түвшний ерөнхий хүрээнд хамаарах үзүүлэлтүүдийг логик агуулгаар нь баланслуулж холбосон. Тухайлбал, макро түвшний үзүүлэлтүүд ДНБ оны үнээр, зэрэгцүүлэх үнээр, салбар тус бүрээр баланслагдсан бөгөөд салбарын бүтцэд гарах ирээдүйн өөрчлөлттэй нягт уялдсан.

Макро түвшний эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн ерөнхий тэнцвэр он бүрээр доорх байдлаар хангагдсан.

(Нийт үйлдвэрлэлт+Импорт)=(Завсрын хэрэглээ+Эцсийн хэрэглээ+(Хуримтлал+ Экспорт))

Хөрөнгө оруулалтын нийт дүн нь улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хөрөнгө оруулалтын дүнтэй тэнцэнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь Засгийн

газраас баталсан хөрөнгө оруулалтын 2018-2021 оны хөтөлбөртэй уялдсан байна.

Үзүүлэлтийн дунд хугацааны хүрэх түвшинг урьдчилан тооцохдоо олон улсын нийтлэг жишгээр хоёр үндсэн аргыг хэрэглэв. Эхнийх нь экстраполяцийн арга, хоёрдахь нь зорилтот хүрэх түвшинд тулгуурлан тооцох арга юм. Экстраполяцийн арга нь өнгөрсөн он жилүүдийн өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагад тулгуурладаг бөгөөд ихэвчлэн тухайн үзүүлэлтийн цаашдын өөрчлөлтийн чиг хандлагын буюу трендийн шинжилгээ, тооцоонд үндэслэнэ. Уг арга нь тухайн үзэгдлийн өмнөх он жилүүдийн бодит байдлыг харгалзан үздэгээрээ төлөвлөлтийг илүү бодитой, амьдралд хэрэгжих үндэстэй болгодог давуу талтай юм. Үүний зэрэгцээ боломжтой өгөгдлүүдэд нормативын болон корреляцийн хамаарал, регрессийн шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэсэн.

Дээрээс төлөвлөх зарчмаар макро эдийн засгийн ерөнхий хүрээг тодорхойлсны дараагаар сонгосон зарим салбараар, тухайлбал, эрчим хүч болон хөдөө аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөллийг гаргасан. Энэ нь доороос төлөвлөх арга зүйд хамаарна. Макро түвшний хүрээг салбарын түвшний үзүүлэлтүүдтэй уялдуулах, баланслуулах оролдлогыг хийв.

### **1.3. Эдийн засгийн нөөцийн болон хөгжлийн гадаад орчны шинжилгээ**

Дунд хугацааны хөгжлийн хүрээнд тодорхойлогдсон зорилтууд, үзүүлэлтүүдийн таамагласан түвшинг хангах эдийн засгийн нөөц хангалттай эсэх болон гадаад орчин ямар байгааг тодорхойлох нь бидний таамаглал, төсөөллийн хэрэгжих үндэслэл хэр зэрэг байгааг харуулах болно. Олон улсын нийтлэг жишгээр төлөвлөлтийг хийхдээ эдийн засгийн нөөцийг урьдчилан тодорхойлдог.

#### **1.3.1. Эдийн засгийн нөөцийн шинжилгээ**

##### **1.3.1.1. Хүн ам, хөдөлмөрийн нөөц**

Монгол Улсын хүн амын тоо 3,2 саяд хүрсэн бөгөөд хүн ам зүйн судлаачдын үзэж байгаагаар одоо хүн ам зүйн “цонх” үе тохиож байгаа ажээ<sup>1</sup>. Энэ нь хөдөлмөрийн насанд шилжсэн хүн амын нийт хүн амд эзлэх хувь хамгийн дээд цэгтээ хүрсэн үе бөгөөд ойрын 20 гаруй жил үргэлжлэх тул улс орны эдийн засгийн хөгжилд нэн тааламжтай хүн ам зүйн нөхцөл бүрдсэн үе гэж үзэж болно.

#### **Хүснэгт 1. Монгол Улсын хүн амын тоо (мянга)**

<b>Хүн амын тоо, хүйс, хот, хөдөөгөөр</b>	<b>2000</b>	<b>2005</b>	<b>2010</b>	<b>2015</b>	<b>2016</b>	<b>2017</b>
<b>Бүгд</b>	2 403.1	2 551.1	2 761	3 057.8	3 119.9	3 177.9
<b>Эрэгтэй</b>	1 190.2	1 265.6	1 342.1	1 503.6	1 534	1 562.4
<b>Эмэгтэй</b>	1 212.9	1 285.5	1 418.9	1 554.2	1 585.9	1 615.5
<b>Хот</b>	1 361.3	1 579.4	1 910.8	2 096.2	2 131.8	2 146.7
<b>Улаанбаатар</b>	794.4	1 016	1 244.5	1 396.3	1 440.4	1 463
<b>Хөдөө</b>	1 041.8	971.7	850.2	961.6	988.1	1031.2
<b>Хүн амын жилийн дундаж тоо</b>						

1. УСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

**БҮЛЭГ 1. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭГ  
ТОДОРХОЙЛСОН ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ**

<b>Бүгд</b>	<b>2 390.5</b>	<b>2 536.4</b>	<b>2 738.6</b>	<b>3 026.8</b>	<b>3 088.9</b>	<b>3 148.9</b>
<b>Эрэгтэй</b>	1 185.2	1 258.3	1 347.6	1 485	1 518.8	1 548.2
<b>Эмэгтэй</b>	1 205.3	1 278.1	1 391	1 541.8	1 570.1	1 600.7

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

Харамсалтай нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хүндрэлтэй, ажилгүйдлийн түвшин тууштай буурахгүй байна. Тухайлбал, 2017 оны байдлаар 119 мянган хүн ажилгүй байв. Энэ нь нэг талаас хөдөлмөр эрхлэх боломжтой хүний тоо цөөнгүй байгааг харуулж байгаа боловч бодит байдал дээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хооронд ихээхэн зөрүү гарсныг энэ чиглэлээр хийгдсэн судалгаанууд нотолж байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд ажлын байр цөөнгүй байгаа боловч түүнд тавигдах шаардлагыг хангасан хүний тоо хангалтгүй байгаагаар илэрч байгаа юм.

**Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн 2010-2017 оны үндсэн үзүүлэлтүүд  
(мянга)**

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)</b>	61.6	62.5	63.5	61.9	62.1	61.5	60.5	61.1
<b>Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хувь)</b>	55.5	57.7	58.3	57.0	57.2	56.9	54.5	55.8
<b>Ажилгүйдлийн түвшин (хувь)</b>	9.9	7.7	8.2	7.9	7.9	7.5	10.0	8.8
<b>Эдийн засгийн идэвхтэй хүн ам (мянга)</b>	1147.1	1124.7	1151.1	1198.3	1206.5	1243.9	1275.6	1357.4
<b>Ажиллагчид (мянга)</b>	1033.7	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2	1147.8	1238.3
<b>Ажилгүй иргэд (мянга)</b>	113.4	87.0	94.7	94.7	95.8	92.6	127.8	119.1

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

Хүснэгтээс харахад 2010 оноос хойш хөдөлмөр эрхлэлтийн түвшин төдийлөн нэмэгдээгүй, үндсэндээ нэг түвшинд буюу 55,5-55,8 хувийн хооронд байжээ.

2018-2025 оны эдийн засгийн өсөлтийг хангахад шаардагдах хүний нөөцийн хувьд анхаарах асуудал цөөнгүй байна. Юуны өмнө өнөөгийн боловсролын тогтолцоо, бэлтгэн гаргаж байгаа мэргэжилтний мэргэжил, мэргэшлийн түвшин, ажлын дадлага, ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэхгүй байна. Зарим ажил мэргэжлээр, тухайлбал, хөнгөн үйлдвэр, ноос, ноолуурын салбарт ажиллах мэргэжилтэн, зохих ур чадвартай ажилчдын эрэлт хэрэгцээ их байхад бэлтгэн гаргаж байгаа ажилчдын тоо хэтэрхий цөөн ажээ.

Ер нь боловсролын салбарт дээд болон мэргэжлийн боловсролын суралцагчдын тооны харьцаа алдагдсан бөгөөд залуучууд дээд боловсролыг олон зуун мянгаараа эзэмшин гарч байгаа боловч зах зээлд шаардлагатай нарийн мэргэжлийн ажилчид хомсдолтой байна.

### 1.3.1.2. Байгалийн нөөц баялаг

Монгол Улсад Менделеевийн үелэх системийн<sup>2</sup> бараг бүх элемент бүртгэгдсэн байдаг бөгөөд энэ нь манай орныг ашигт малтмалаар арвин улс болохыг илтгэж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өнөөгийн байдлаар 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий 1000 гаруй орд газар, 8000 гаруй илрэл<sup>3</sup> бүртгэгдсэн ажээ.

### Хүснэгт 3. Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн зах зээлийн үнэлгээ (2018 оны 5 сарын байдлаар, сая доллар)

№	Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	Геологийн нөөц, (Хүдэр)	Геологийн нөөц, (Металл)	Зах зээлийн үнэ	Дэлхийн зах зээлийн үнэ
1	Алт (Үндсэн)	мян.тонн/кг	384290.8	460142	19451.1	1348.04
2	Алт (шороон)	мян.м3/кг	761824.7	248580	10507.9	1348.04
3	Мөнгө	мян.тонн/тонн	46442.4	6497.69	3.4	16.28
4	Төмрийн хүдэр	мян.тонн	1860542.9	460629	32115	69.72
5	Коксжих нүүрс	сая тонн	1215.3	1215.3	296431.1	243.9
6	Эрчим хүчний нүүрс	сая тонн	31588.7	31588.7	1942707.5	61.5
7	Цайр	мян.тонн	25072.8	1785.8	5948.7	3331
8	Зэс	мян.тонн	11444179.6	79548.6	529555.2	6657
9	Хайлуур жонш	мян тонн	392747.8	101673.2	39652.5	390
10	Газрын тос	сая тонн		332.64	21874.4	65.76
11	Уран	мян.тонн/тонн	563708.8	173711.76	3.6	21
12	Фосфорит	мян.тонн	223853.2	46157.7	5769.7	125
13	Молибден	мян.тонн/тонн	1199258.5	11546663.1	277119.9	24000
14	Газрын ховор элемент	мян.тонн/тонн	416238.2	2268552.2		
15	Цагаан тугалга	мян.м3/тонн	43577.4	24529.46	517.5	21100
16	Хар тугалга	мян.тонн	61391.1	1689	4070.4	2410
17	Гянтболд	мян.тонн/тонн	499149.3	422380.5	147.8	350
	Нийт				3,185,876.5	

Эх сурвалж: АМГТГ-ын ашигт малтмалын бүртгээгдсэн нөөцийн хэмжээ, 2018 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн байдлаар.

Тайлбар: Нийт нөөцийн хэмжээг ашигт малтмалын нөөцийн бүртгэлээс авсан тул нөөцийн хөдөлгөөн ороогүй болно. Нүүрсний нөөцийг Нүүрсний судалгааны хэлтсээс, газрын тосны нөөцийг Геологи хайгуулын хэлтсээс тус тус авч нэгтгэсэн.

Хүснэгт 3-аас харахад Монгол Улсын зөвхөн 17 ашигт малтмалын нөөцийн одоогийн үнэлгээ 3,1 их наяд доллартай тэнцүү буюу 1 хүнд 1 сая долларын байгалийн баялгийн нөөц оногдож байна. Үүнээс 708 тонн алтны нөөцийн зах зээлийн үнэлгээ 29,9

2. Менделеевийн үелэх систем гэдэг нь мэдэгдэж буй химийн элементүүдийн жагсаалт юм.
3. НҮБ, Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ, Монгол Улс.



тэрбум доллар буюу нийт нөөцийн 0,9 хувь, 460 сая тонн төмрийн хүдрийн нөөцийн зах зээлийн үнэлгээ 32,1 тэрбум доллар буюу нийт нөөцийн 1 хувь, 1,2 тэрбум тонн коксжих нүүрсний нөөцийн зах зээлийн үнэлгээ 296,4 тэрбум доллар буюу нийт нөөцийн 9,3 хувь, 31,5 тэрбум тонн эрчим хүчний нүүрсний нөөцийн зах зээлийн үнэлгээ 1.942,7 тэрбум доллар буюу нийт нөөцийн 61 хувь, 79,5 сая тонн зэсийн нөөцийн зах зээлийн үнэлгээ 5295 тэрбум доллар буюу нийт нөөцийн 16,6 хувь, 101,6 сая тонн хайлуур жоншны нөөцийн зах зээлийн үнэлгээ 39,6 тэрбум доллар буюу нийт нөөцийн 1,2 хувь, 332,6 сая тонн газрын тосны нөөцийн зах зээлийн үнэлгээ 21,8 тэрбум доллар буюу нийт нөөцийн 0,7 хувь, 11,5 сая тонн молибдений нөөцийн зах зээлийн үнэлгээ 277,1 тэрбум доллар буюу нийт нөөцийн 8,7 хувийг тус тус бүрдүүлж байна.

Монгол Улс 2017 онд 1447,2 мян тонн зэсийн баяжмал экспортолжээ. Хэрэв энэ хэмжээ цаашид хадгалагдвал манай улсын зэсийн нөөц 55 жилийн дараа дуусна. Мөн 2017 онд 6257,9 мянган тонн төмрийн хүдэр экспортолжээ. Хэрэв энэ хэмжээ цаашид хадгалагдвал төмрийн хүдрийн нөөц 73,6 жилийн дараа дуусахаар тооцоо гарч байна. Тэгвэл 2017 онд боловсруулаагүй алт 14,5 тонн экспортолсон бөгөөд цаашид ийм хэмжээгээр экспортлоод байвал 48,8 жилийн дараа алтны нөөц бүрэн дуусахаар байна. Бид экспортолсон уул уурхайн баялгийнхаа 16,3 хувьд нь дөнгөж анхан шатны боловсруулалт хийж, үндсэндээ түүхийгээр нь шууд гаргаж байна.<sup>4</sup>

Үүнээс үзэхэд Монгол Улсад бараг төрөл бүрийн ашигт малтмалын нөөц байгаа бөгөөд эрдэс баялаг, уул уурхайн салбар нь эдийн засагт эзэлж буй хувь хэмжээгээрээ тэргүүлэх салбарын түвшинд хүрч, манай орны хөгжлийг тодорхойлж байна. Гэхдээ нэг хүнд ногдох хэмжээгээр нь тооцож үзвэл Монгол Улс ашигт малтмалын нөөцөөр тийм ч баян улс биш юм. Ялангуяа алт, мөнгө, газрын тос, ураны нөөцөөр ядуу ч улсын тоонд орохоор байна. Иймд, бид алт, зэс, төмрийн хүдэр олборлох хэмжээг бууруулах, аль болохоор бүрэн гүйцэд боловсруулах замаар байгаа нөөцөө өөрсдөө ашиглах цаг аль хэдийнээ болжээ. Ялангуяа алтны экспортыг бүрэн зогсоох шаардлагатай байна.

### **1.3.1.3. Эдийн засгийн нийт болон тодорхой төрлийн нөөц**

Макро эдийн засгийн түвшинд Үндэсний тооцооны системийн тооцооны нийт үйлдвэрлэл ба импортын дүн нь эдийн засгийн нийт нөөцийн нийлүүлэлтийг илэрхийлдэг бол (Завсрын хэрэглээ) + (Эцсийн хэрэглээ) + (Хуримтлал) + (Экспорт) гэсэн нийлбэр нь нийт эрэлт буюу эдийн засгийн нөөцийн ашиглалтыг харуулдаг.

### **Хүснэгт 4. Макро эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ ба бүтэц, оны үнээр (тэрбум төгрөг)**

	2005	2010	2015	2016	2017	Дүнд эзлэх хувь			
						2005	2010	2015	2017
<b>Нийт нөөц</b>	7741.7	24447.4	53375.3	55380	67358.9	100	100	100	100
<b>Нийт үйлдвэрлэл үндсэн үнээр</b>	5495.3	17919.9	41154.9	42516.7	48810.1	71	73.3	76.8	72.5
<b>Импорт</b>	1934.7	5529.2	10334.7	10872.6	16008.9	25	22.6	19.6	23.8
<b>Бүтээгдэхүүний цэвэр татвар</b>	311.7	998.3	1885.7	1990.8	2539.8	4	4.1	3.6	3.7
<b>Нийт эрэлт</b>	7741.7	24447.4	53375.3	55 380	67358.9	100	100	100	100

4. УСХ, Статистикийн эмхэтгэл, 2017

**БҮЛЭГ 1. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭГ  
ТОДОРХОЙЛСОН ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ**

<b>Завсрын хэрэглээ</b>	2765.7	9161.6	19890.2	20564.6	24182.9	35.7	37.5	37.3	35.8
<b>Эцсийн хэрэглээ</b>	2231.5	6625.2	16803.3	16634.2	17233.7	28.8	27.1	31.5	25.5
<b>Хуримтлал</b>	1141.4	4106.2	6114.6	6161.6	10135	14.8	16.8	11.5	15
<b>Экспорт</b>	1603.1	4554.4	10567.1	12019.5	15807.2	20.7	18.6	19.8	23.4

Эх сурвалж: УСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, Үндэсний тооцооны нэгдсэн данснууд, 2016-2017.

Монгол Улсын эдийн засгийн нийт нөөц 2017 онд 67,4 их наяд төгрөг байжээ.

Хүснэгт 4-өөс харахад эдийн засгийн нийт нөөцийн дүнд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь 2005 онд 71 хувь байсан бол 2016 онд 76,3 хувьд хүрч нэмэгдсэн боловч 2017 онд эргээд 72,5 хувь болж буурчээ. Үүний зэрэгцээ эдийн засгийн нийт нөөцийн дүнд импортын эзлэх хувь дээрх хугацаанд 25-23,8 хувь болж бага зэрэг буурчээ.

Нийт нөөцийн ашиглалтын бүтцийг авч үзэж, 2017 оныг 2005 онтой харьцуулахад завсрын хэрэглээ буюу үйлдвэрлэлийн зориулалттай зардал болон хуримтлалын эзлэх хувьд мэдэгдэхүйц томоохон өөрчлөлт гараагүй үндсэндээ тогтвортой байна. Харин эдийн засгийн нөөцөд эцсийн хэрэглээний эзлэх хувь 2005 онд 28,8 хувь байснаа 2017 онд 23,7 хувь болж буурчээ. Эдийн засгийн нийт нөөцийн дүнд манай экспортын эзлэх хувь 2017 онд өмнөх онуудаас нэмэгдсэн эерэг хандлага гарчээ. Гэвч энэ нь тайвшрах үр дүн биш, үндсэндээ зөвхөн нүүрсний экспортоос гарсан эерэг үр дүн юм.

Цаашид эдийн засгийн үйл ажиллагааг явуулахад оролцдог газрын хэмжээг авч үзье.

**Хүснэгт 5. Монгол Улсын газрын нэгдмэл сан, үндсэн ангиллаар**  
(мянган га)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Нийт талбайн хэмжээ</b>	156411.6	156411.6	156411.6	156411.6	156411.6	156411.6	156411.6	156411.6
<b>Хөдөө аж ахуйн газар</b>	115525.8	115490.8	115399.9	115361.4	115008.6	114982.8	114931.1	114843.5
<b>Хот, тосгон, бусад суурин газар</b>	620.6	667.3	702	699.6	712.1	716.9	753.6	840.1
<b>Зам, шугам, сүлжээний газар</b>	407.1	429.2	435.3	437.3	454.8	462.5	473.8	471.7
<b>Ойн сан бүхий газар</b>	14297.9	14260.0	14256.5	14295.4	14320.5	14334.4	14334.3	14341.2
<b>Усны сан бүхий газар</b>	682.8	686.8	686.8	686.7	686.7	686.1	686.1	686.1
<b>Тусгай хэрэгцээний газар</b>	24877.4	24877.4	24931.1	24931.1	25228.9	25228.9	25232.7	25228.9

Эх сурвалж: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар.

Манай орны хувьд эдийн засгийн эргэлтэд орсон газар нутгийн хэмжээ нийт нутаг дэвсгэртэй харьцуулахад харьцангуй бага, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах газрын нөөц Улаанбаатар хотоос бусад байршилд хангалттай хэмжээтэй байгаа юм.

**1.3.2. Монгол Улсын хөгжлийн гадаад орчны шинжилгээ**

2010-2017 онд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт үнийн дүнгээрээ 1,7 дахин өсөхөд боловсруулах үйлдвэрлэлийн сэргэлт, гадаад зах зээл дээрх уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн өсөлтөд эерэг нөлөөлсөн байна. Гадаад зах зээлийн үнэ өссөнөөр уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, геологи хайгуулын болон олборлолтын ажлууд идэвхжиж, шинэ ашигт малтмалын ордуудыг ашиглах болж, уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг, материал болон газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ өсч, улмаар уул уурхайн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт нэмэгдэх болсон юм. Ийнхүү гадаад худалдааны нийт эргэлтийг нэмэгдүүлэхэд экспортын барааны өсөлт чухал үүрэг гүйцэтгэжээ.

**Хүснэгт 6. 2010-2017 оны Монгол Улсын гадаад худалдааны эргэлт  
(сая ам.доллар)**

Он	Гадаад худалдааны эргэлт	Экспортын хэмжээ	Экспортын квот	Импортын хэмжээ	Импортын квот	Гадаад худалдааны тэнцэл
2010	6177.1	2899.2	46.9	3277.9	53.1	-378.7
2011	11416	4817.5	42.2	6598.4	57.8	-1781
2012	11123	4384.7	39.4	6738.4	60.6	-2354
2013	10627	4269.1	40.2	6357.8	59.8	-2089
2014	11011	5774.3	52.4	5236.7	47.6	537.6
2015	8466.8	4669.3	55.1	3797.5	44.9	871.8
2016	8274.5	4916.3	59.4	3358.1	40.6	1558.2
2017	10537.9	6200.6	58.8	4337.3	41.2	1863.3

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

2010-2017 онд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 1,7 дахин өссөн бол экспорт 2,1 дахин, импорт 1,3 дахин нэмэгджээ. Харин 2013 он хүртэл гадаад худалдаа алдагдалтай гарч байсан бол 2014 оноос эхлэн ашигтай болж 2017 оны байдлаар 1,8 тэрбум долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдаа ашигтай гарахад “Оюу толгой” зэсийн болон “Таван толгой” нүүрсний экспорт үлэмж хувь нэмэр оруулжээ.

Нөгөө талаас, сүүлийн 7 жилд гадаад худалдаанд экспортын эзлэх хувийн жин буюу экспортын квот 46-58 хувь болж өссөн байхад импортын квот 53-41 хувь болон буурч, гадаад худалдааны нөхцөл сайжирчээ.

Хэдийгээр манай улсын гадаад худалдааны нөхцөл байдал сайжирч байгаа ч гэсэн тэр нь дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнийн өөрчлөлт, урд хөршийн эдийн засаг, аж үйлдвэрийн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай болсон байна. Манай улсын экспортын бүтцэд уул уурхай, олборлох салбарын түүхий эд давамгайлах болжээ. Гадаад зах зээл дээр үнэ өсөхөд уул уурхайн түүхий эдийн биет хэмжээ болон экспортын орлого нэмэгдэж, энэ нь улс орны эдийн засгийг тэлж, импортын хэмжээг ямар ч удирдлагагүй шахам нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Манай улсын экспортын барааны бүтцийг авч үзвэл эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бус бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн 98,5 хувийг эзэлж байна.

Иймд экспортын бүтцэд түүхий эдийн эзлэх хувийн жинг багасгаж, бэлэн бүтээгдэхүүний хувийн жинг нэмэгдүүлэх нь дотоодын үйлдвэрлэл, хүн амын ажил

эрхлэлт, амьжиргаа болон төсвийн орлого, гадаад валютын орлогыг өсгөх, улмаар валютын ханшийг тогтворжуулах зэрэг олон эерэг үр дагавартай болохыг анхаарах шаарлагатай байна.

Импортын бүтцэд машин, механизм, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, цахилгаан хэрэгсэл, сэлбэг болон эрдэс бүтээгдэхүүн 50 гаруй хувийг эзэлж байна. Дотоод зах зээлийн хэрэглээг хангахад шатахуун түлш, тээврийн хэрэгсэл, машин, техник, тоног төхөөрөмжийн импорт чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гадаад худалдааны тэнцвэрт экспорт, импортын барааны үнийн хэлбэлзэл ихээхэн нөлөөлж байгаагаас гадна импортлогч орны сонголт цөөхөн байгаа нь алдагдлыг бий болгож байна. Импортын хэмжээ жил тутам нэмэгдэхэд уул уурхай, олборлох үйлдвэрт шаардлагатай машин, техник хэрэгслийн импортын хэрэгцээ нэмэгдсэн, нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөн зэрэг нь нөлөөлжээ.

### Хүснэгт 7. Монгол Улсын гадаад худалдаанд хөрш орнуудын эзлэх хувийн жин (хувь)

Он	Гадаад худалдааны эргэлт		Экспорт		Импорт	
	ОХУ	БНХАУ	ОХУ	БНХАУ	ОХУ	БНХАУ
2010	18.4	56.2	2.8	84.7	32.7	30.3
2011	15.0	56.6	1.9	92.1	24.6	30.6
2012	17.3	53.2	1.8	92.5	27.4	27.6
2013	15.3	52	1.4	86.8	24.5	28.6
2014	14.6	62.1	1	87.9	29.6	33.8
2015	12.9	62.6	1.6	83.7	26.8	36.6
2016	18.8	59.9	1.1	79.4	26.2	31.6
2017	12.2	63.9	1.1	85.6	28.1	32.9

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

2010 онд Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд Оросын Холбооны Улс (ОХУ) 18,4 хувийг эзэлж байсан бол жил тутам буурч 2017 онд 12,2 хувь болжээ. Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) 2010 онд 56,2 хувийг эзэлж байсан бол 2017 онд 63,9 хувийг эзлэх болжээ. Өөрөөр хэлбэл, манай улсын гадаад худалдааны эргэлтэд ОХУ-ын хувийн жин буурч байхад БНХАУ-ын хувийн жин жил тутам өсөж байна.

2010 онд манай улсын экспортын 2,8 хувь ОХУ-руу гарч байсан бол 2017 онд 1,1 хувь болж буурчээ. Харин 2010 онд 87,4 хувь нь БНХАУ руу гарч байсан бол 2017 онд 85,6 хувь болжээ. ОХУ-руу гаргах экспорт үндсэндээ зогссон байна гэж дүгнэж болно.


**Хүснэгт 8. Монгол Улсын гадаад худалдаанд дэлхийн томоохон улсуудын эзлэх хувийн жин (хувь)**

Он	АНУ	Европын холбоо	Япон	Өмнөд Солонгос
2010	2.7	12.3	3.2	3.4
2011	4.7	7.2	4.3	3.4
2012	4.8	5.9	4.5	4.3
2013	6.2	5.8	5.5	6.3
2014	3	8.1	4.7	4.4
2015	1.6	4.7	3.6	3.9
2016	1.8	4.9	4.2	2.4
2017	2.1	5	3.6	2

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

Өнгөрсөн хугацаанд манай улсын гадаад худалдаанд хөрш хоёр орны эзлэх хувийн жин нэмэгдсэн байхад Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос улсын хувийн жин буурчээ.

**Зураг 1. Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ (сая тонн)**



Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2016.

Монгол улс 2003 оноос эхлэн нүүрс экспортлох болсон бөгөөд түүний хэмжээ тогтмол өсөх хадлагатай байна. Сүүлийн 2 жилд манай улс нийт олборлосон нүүрснийхээ 60 гаруй хувийг дотооддоо ахуйн болон дулааны цахилгаан станцид эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашиглаж, 30 гаруй хувийг БНХАУ-д экспортолж гаргажээ.

**Хүснэгт 9. ОУВС-аас гаргасан Дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлтийн таамаглал**

(хувь)

Он	Дэлхийн нийт	АНУ	Европын Холбоо	Япон	G7 орнууд	Зүүн Ази
2015	3.5	2.9	2.4	1.4	2.1	7.6
2016	3.3	1.6	2	1	1.5	6.8
2017	3.7	2.2	2.7	1.7	2.1	6.5
2018	3.7	2.9	2.2	1.1	2.2	7.1
2019	3.7	2.5	2.0	0.9	2	7
2020	3.7	1.8	1.8	0.3	1.5	7.2
2021	3.6	1.7	1.7	0.7	1.5	7.3
2022	3.6	1.5	1.7	0.5	1.3	7.2
2023	3.6	1.4	1.6	0.5	1.2	7.3

Эх сурвалж: ОУВС-ын цахим хуудас, [www.imf.org/external/datamapper/](http://www.imf.org/external/datamapper/).

Дэлхийн эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг аж үйлдвэржсэн улс орнуудын эдийн засгийн өсөлт 2019 оноос эхлэн буурах таамаглалыг Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргасныг Хүснэгт 9-өөс харж болно. Ялангуяа аж үйлдвэржсэн тэргүүлэх 7 орны зах зээлийн нөхцөл байдал муудаж, түүний дотор АНУ, Япон, Европын холбооны эдийн засаг суларч, дэлхийн зах зээл дээрх гол нэрийн түүхий эд, барааны эрэлтийг бууруулах хандлагатай байна. Тэгвэл Зүүн Азийн орнуудын эдийн засгийн нөхцөл байдал тийм ч ноцтой муудахааргүй таамаглал гарсан нь манай улсад эерэг нөлөө үзүүлж мэдэх юм.

ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт нь ерөнхийдөө аажмаар багасах төлөвтэй байгаа ч энэ нь манай улсын эдийн засагт тийм ч ноцтой, огцом сөрөг нөлөөг үзүүлэх хэмжээнд хүрэхгүй байх гэсэн найдлагыг төрүүлж байна.

**Хүснэгт 10. Дэлхийн зах зээл дээрх манай улсын экспортын зарим барааны үнийн таамаглал**

(ам.доллар)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Зэс</b>	6800	6816	6833	6849	6866	6883	6899	6916
<b>Нүүрс</b>	85	75	65	64	64	63.5	63	62.4
<b>Төмрийн хүдэр</b>	64	60	55	55.9	56.9	57.8	58.8	59.8
<b>Цайр</b>	3200	2900	2500	2490	2480	2470	2460	2449
<b>Алт</b>	985	1020	1057	1094	1133	1174	1216	1259

Эх сурвалж: Дэлхийн Банк, Дэлхийн зах зээлийн үнийн таамаглал.

Дээрх хүснэгтээс харахад 2019-2025 онд дэлхийн зах зээл дээр алтны үнэ дунджаар 3,5 хувь, зэсийн үнэ 0,25 хувиар тус тус өсөхөөр байна. Харин 2018-2020 онд нүүрсний үнэ жилд дунджаар 11 хувь, төмрийн хүдрийн үнэ 6-8 хувиар буурч, 2021 оноос жилд дунджаар 1,6 хувиар өсөхөөр байна. Цайрын үнэ 2018-2020 онд 9-18 хувиар унах бөгөөд харин 2021 оноос уналтын эрч саарч, жилд дунджаар 0,4 хувь болох таамаглалыг ДБ-аас хийжээ. Одоогийн байдлаар манай улсын экспортын орлогын ихээхэн хэсгийг бүрдүүлж байгаа нүүрс, төмрийн хүдрийн экспортын орлогын хэмжээ багасах эрсдэлийг зэс, алтны экспортын орлогоор нөхөх найдлага байна.



#### **1.4. Нөхцөл байдлын шинжилгээнээс гарсан ерөнхий дүгнэлт**

Манай орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2018-2025 оны үндсэн үзүүлэлтүүдийн болон салбаруудын хөгжлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг хийхдээ сүүлийн 17 жилийн (2000-2017) хөгжил, өөрчлөлтийг шинжиж, цаашдын чиг хандлагыг тооцож, дунд хугацааны төсөөлөлдөө барих гол баримжаа болгон авч үзэв. Ингэснээр, амьдралын бодит нөхцөл байдалд илүү ойрхон, хэрэгжих үндэслэлтэй дунд хугацааны тооцоог хийх боломжтой болсон. Үүний зэрэгцээ МУТХҮБ-2030-д эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалах талаар дэвшүүлсэн бодлогын зорилтууд болон үндсэн үзүүлэлтүүдийг 2025 онд хүргэхээр дэвшүүлсэн зорилтот түвшинг харгалзан үзсэн болно.

Монгол Улсын хувьд эдийн засаг, нийгмийн хөгжил, улс төрийн үйл явц нь гадаад, дотоод олон хүчин зүйлийн нөлөөлөл доор урьдчилан таамаглахад хэцүү, тодорхой бус байдал бий болсон онцлогтой цаг үед өрнөж байгааг хэлэх хэрэгтэй. Ийм учраас, дунд хугацааны хөгжлийн хүрээний гол үзүүлэлтүүдийг доод, дунд, дээд гэсэн 3 хувилбараар авч үзэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарсан. Доод хувилбар нь үйл явцын өрнөлийн таагүй нөхцөлөөр, дунд хувилбар нь өнөөгийн бодит нөхцөлд илүү ойр дундаж нөхцлөөр, дээд хувилбар нь илүү таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд авч үзсэн хувилбар юм.

Нөхцөл байдлын шинжилгээнээс үзэхэд манай орон гадаад өрийн хүнд дарамтад орсон, экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нь БНХАУ-ын ганц зах зээлээс шууд хараат, шатахууны хувьд ОХУ-аас бүрэн хараат (98 хувийг авдаг), орлогын гол эх үүсвэр болох уул уурхайн бүтээгдэхүүнээс олох орлого нь эрдэс түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнээс шууд хамааралтай зэрэг шалтгааны улмаас эдийн засаг маань бүхэлдээ эмзэг, эрсдэл өндөртэй болоод байна. Эдийн засгийн өөр нэг гол салбар хөдөө аж ахуй (ХАА) нь байгаль, цаг уурын нөхцөлөөс шууд хамааралтай учир ган, зуд тохиоход мал хорогдож, мал аж ахуйд ихээхэн гарз хохирол учирдаг бол газар тариаланд ургац алддаг хэвээр байна.

2017 онд чулуун нүүрсний 97,9 хувь, зэсийн баяжмалын 100 хувь, молибдены баяжмалын экспортын 92,7 хувь, хайлуур жоншны 42 хувь, төмрийн хүдрийн 100 хувийг тус тус БНХАУ руу экспортолжээ.

БНХАУ COP-21<sup>5</sup> гэрээнд нэгдсэнээр дэлхийн дулаарлын үйл явцад үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор нүүрснийхээ хэрэгцээг хязгаарлах бодлого явуулж эхэлсэн тул цаашдаа Монгол Улс нүүрс экспортолж, орлогынхоо үлэмж хэсгийг олдог арга зам хязгаарлагдаж болзошгүй юм.


Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нүүрлэж болзошгүй, тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байгаа талаар гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, шинжээчид дүгнэж байна. Энэ нь манай эдийн засагт ч таагүй нөлөө үзүүлэх магадлалтай юм.

Өнгөрсөн 17 жилийн эдийн засгийн төлөв байдлаас харахад манай орны эдийн засагт өсөлт, бууралт ээлжилдэг цикл бий болжээ.

---

5. COP-21 - Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар НҮБ-ын суурь конвенцийн талуудын 21 дүгээр уулзалт Франц улсын нийслэл Парис хотноо, 2015 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан.

**Зураг 2. ДНБ-ий жил бүрийн өсөлтийн хувь, 2010 оны зэрэгцүүлэх үнээр**



Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017.

2010 оноос өмнө ган, зуд болж, мал аж ахуйн салбар уналтад орсонтой гол төлөв холбоотойгоор эдийн засгийн өсөлт саарч байсан бол 2010 оноос хойш уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хамт дэлхийн зах зээлд эрдэс түүхий эдийн үнэ унаж, гадаад зах зээлийн орчин нөхцөл муудсантай холбоотойгоор эдийн засаг буурч байжээ.

Манай эдийн засгийн тэлэлт, агшилтын буюу өсөлт, бууралтын циклийг 2018-2025 онуудад цаашид ч үргэлжилнэ хэмээн төсөөллөө.

Нөгөө талаас, манай орны эдийн засгийн ойрын жилүүдийн өсөлтөд доорх 5 хүчин зүйл зайлшгүй нөлөөлнө гэж үзсэн. Үүнд:

1. Манай орны эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хараат байгаа бөгөөд энэ байдал 2025 он хүртэл үргэлжилнэ. Иймээс, манай орны экспортын гол түүхий эдийн гадаад зах зээл дэх үнийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлт, бууралтад шууд нөлөөлнө гэж үзсэн. Өмнөх гадаад нөхцөл байдлын шинжилгээ болон Хүснэгт 10-д харуулсан манай экспортын барааны дэлхийн зах зээлийн үнийн таамаглалаар 2019 оноос нүүрсний үнэ тасралтгүй буурах төлөвтэй байна. Иймд, манай эдийн засаг тогтвортой, байнга өснө гэсэн таамаглал дэвшүүлэх боломжгүй бөгөөд харин ч зарим жилд буурах үе тохионо гэж үзэв.

2. Манай орны эдийн засгийн эмзэг байдал 2019-2025 онуудад хэвээр үргэлжилнэ. Ялангуяа, 2020-2023 онд өмнөх онуудын үндсэн зээлийн гол хэсгийн төлбөр хийгдэж, гадаад өрийн дарамт улам нэмэгдэх тул улсын төсөвт хүндрэл, дарамт учрахыг харгалзан үзвэл зохино. Иймээс, төсвийн хөрөнгө оруулалт энэ үед эрс буурч, бүтээн босголтын ажил нэлээд хязгаарлагдана гэж тооцсон.

3. Томоохон төслүүд, үүний дотор "Таван толгой" төсөл хэрхэн хэрэгжиж эхлэхээс 2020-2025 оны эдийн засгийн өсөлт ихээхэн хамаарах болно. Мөн "Оюу толгой" далд уурхайн ашиглалт 2022 оноос эрс нэмэгдэх бөгөөд манай эдийн засагт үүний үзүүлэх нөлөөг харгалзан тооцов.

4. Улс төрийн сонгууль дагасан засаглалын өөрчлөлтийн цикл мөн эдийн

засагт тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Энэ нь эдийн засгийн салбарт гарах бодлогын өөрчлөлт, томоохон төслүүдийн хэрэгжилтийн явц зэргээр дамжин эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө. Ялангуяа шинэ удирдлага гарснаар өмнө эхлүүлсэн ололттой зүйл, томоохон төсөл, хөтөлбөрүүдээ уламжлан үргэлжлүүлэх эсэх, хууль эрх зүйн орчноо тогтвортой байлгах эсэх, үүнтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх юмуу багасах эсэхээс эдийн засгийн идэвхжил, өсөлт ихээхэн хамаарна.

5. Төгсгөлд нь манай орны эдийн засгийн гадаад орчны өөрчлөлт, нөлөөг зайлшгүй харгалзан үзнэ. Ялангуяа, АНУ, БНХАУ болон Европын холбооны хооронд өрнөж эхэлсэн худалдааны дайн 2019-2025 онуудад хэвээр үргэлжлэх магадлалтай байна. Энэхүү худалдааны дайны сөрөг нөлөөг өөрийн улс орондоо ашигтайгаар эргүүлж чадах эсэхээс эдийн засгийн өсөлт мөн хамаарна.

Түүнчлэн, АНУ-ын Холбооны Нөөцийн банк (ХНБ) ам.долларын бодлогын хүүгээ өсгөснөөс болон өөр бусад шалтгаанаар Монгол төгрөгийн ханш суларсаар байгааг цаашид тооцож үзвэл зохино.

Эдгээр хүчин зүйлсийн манай орны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг SDG-SIM загвараар симуляци хийх замаар эерэг ба сөрөг талаас нь тооцож, гарсан үр дүнг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд тусгасан.

## БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

### 2.1. 2018-2025 оны макро эдийн засгийн ерөнхий хүрээний төсөөлөл

Макро эдийн засгийн ерөнхий хүрээг аргачлалын хэсэгт үндсэн 9 үзүүлэлтээр төсөөлөх тухай дурдсан. Эхний үзүүлэлт нь эдийн засгийн өсөлтийг илэрхийлэгч ДНБ-ий бодит өсөлтийн төсөөлөл юм.


#### 2.1.1. ДНБ-ий 2018-2025 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлтийн таамаглал бол дунд хугацааны төвлөвлөлтийн хамгийн гол үзүүлэлтийн нэг төдийгүй бусад үзүүлэлтүүдэд нөлөөлж, улс орны ирээдүйн дүр төрхийг бүхэлд нь төсөөлөхөд шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Бид нөхцөл байдлын шинжилгээний үндсэн дээр Монгол Улсын эдийн засагт явагдаж ирсэн өсөлт, бууралтын цикл нь цаашдаа ч үргэлжилнэ гэж төсөөлсөн.

Олон улсын санхүү, эдийн засгийн гол байгууллагууд болон Сангийн яам Монгол Улсын эдийн засгийн ойрын жилүүдийн өсөлтийг хэрхэн төсөөлж байгааг доорх зурагт харуулав.

### Зураг 3. Олон улсын байгууллагууд болон Сангийн яамнаас Монгол Улсын ДНБ-ий ойрын жилүүдийн өсөлтөөр гаргасан таамаглал (хувь)



Эх сурвалж: 1. ДБ, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2018.

2. ОУВС, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2018.

3. АХБ, Азийн хөгжлийн хэтийн төлөв, 2018.

4. АНУ, Хөдөө аж ахуйн яам, Олон улсын макро эдийн засгийн тоон өгөгдлийн сан, 2018.


Зургаас харахад, Монгол Улсын ойрын жилүүдийн эдийн засгийн өсөлтийг янз бүрээр төсөөлсөн боловч Азийн хөгжлийн банкнаас (АХБ) бусад газрууд 2019 онд манай эдийн засгийг өмнөх 2018 оныхоосоо нэлээд өндөр өсөлттэй байна гэж үзжээ.

Ялангуяа, Сангийн яам 2018 оны 11 дүгээр сард УИХ-д 2019 оны төсвийн төслийг оруулахдаа 2019 онд эдийн засаг 8 хувийн өсөлттэй байхаар төсөөлсөн бол Дэлхийн банкны төсөөллөөр 7,3 хувь гарчээ.

Монгол Улсын эдийн засгийн 2018-2025 оны төсөөллийг хийхдээ юуны түрүүнд 2000-2017 оны ДНБ-ий бодит гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн. 2000-2017 оны ДНБ-ий бодит өсөлтийг суурь 2000 онтой харьцуулсан чиг хандлагыг доорх зурагт харуулав.

**Зураг 4. ДНБ-ий суурь онтой (2000=1) харьцуулсан өсөлтийн түвшин, цаашдын чиг хандлага, 2010 оны зэрэгцүүлэх үнээр**

(хувь)



Эх сурвалж: YCX, Статистикийн эмхэтгэл, 2010, 2015, 2017, YXF-ын Судалгааны багийн тооцоо.


Зургаас харахад Монгол Улсын 2017 оны ДНБ-ий хэмжээ 2000 оныхоос 3,1 дахин өсчээ. Өөрөөр хэлбэл, Монголын эдийн засаг сүүлийн 17 жилд 3 дахин тэлжээ. Эндээс тооцоход сүүлийн 17 жилийн эдийн засгийн дундаж өсөлт 6,9 хувь гарч байна. Өнгөрсөн 17 жилийн өсөлтийн төлөвийг хадгалсан нөхцөлд манай орны ДНБ-ий хэмжээ 2025 он гэхэд 2000 оныхоос ойролцоогоор 4,8 дахин нэмэгдэх боломжтойг Excel программ ашиглан 2025 он хүртэл тооцсон трендийн шулуун харуулж байна. Энэхүү трендийн шугам нь үйл явцыг 80,5 хувийн магадлалтай тайлбарлаж чадахыг детерменацын коэффициент харуулна. 2000 онд ДНБ-ий хэмжээ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 5,4 их наяд төгрөг байсан тул түүнийг 4,8 дахин нэмэгдүүлэхэд ДНБ-ий хэмжээ 2025 онд 2010 оны зэрэгцүүлэх үнээр 25,9 их наяд болох тооцоо гарав. Энэ тооцоо нь бидэнд ерөнхий чиг баримжаа өгч байна.

МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн 6,6 хувийн жилийн дундаж өсөлт нь эдийн засгийн хөгжлөө тэтгэж чадвал биелэгдэж болох өсөлт гэдэг нь өнгөрсөн 17 жилийн бодит байдлаас харагдаж байна. Гэхдээ энд нэг онцлог байгааг харгалзан үзвэл зохино. Монгол Улсад уул уурхайн салбар 2000-аад оны дунд үеэс эрчимтэй хөгжиж, БНХАУ-руу гаргах нүүрсний экспорт нэмэгдэж, эдийн засаг огцом тэлж ирсэн тул дээр дурдсан 6,9 хувийн дундаж өсөлтийг бий болгосон билээ.

Харин ирэх 8 жилд буюу 2018-2025 онд ийм өргөн хүрээтэй эдийн засгийн тэлэлт болох магадлал бага байна. Харин ч манай нүүрсний экспорт 2019 оноос буурах магадлалтай байгааг гол худалдан авагч Хятад улсын нөхцөл байдал харуулж байна. Дээр нь нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ 2019 оноос аажимдаа буурах төсөөллийг олон улсын судалгааны байгууллагууд гаргасан. Эцэст нь 2020 оноос дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал нүүрлэж болзошгүйг дэлхийн эдийн засаг санхүүгийн салбарын олон шинжээчид анхааруулжээ. Манай орны хувьд илэрхий

мэдрэгдэж байгаа зүйл бол газрын тос боловсруулах үйлдвэр 2023 онд ашиглалтад орж, эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх явдал юм. Гэхдээ манай орны хувьд ирэх онуудын эдийн засгийн өсөлт нь уул уурхайн бус салбаруудын хөгжил, тэлэлтээс ихээхэн хамааралтай байх нь тодорхой. Энэ бүх нөхцөл байдлыг үнэлээд Монгол Улсын 2018-2025 оны ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг дээд, дунд, доод гэсэн 3 хувилбараар тооцсоныг доорх зурагт харуулав.

**Зураг 5. ДНБ-ий 2018-2025 оны жил бүрийн өсөлтийн төсөөлөл**  
(хувь)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Бид Зураг 5-д Сангийн яам болон ДБ-ны төсөөлсөнтэй адилаар манай орны эдийн засгийн өсөлт 2019 онд 6,3-8 хувийн өсөлттэй байхаар тооцов. Харин 2021 онд эдийн засгийн өсөлт хамгийн доод түвшиндээ хүрэн үлэмж саарч, улмаар 2022 оноос өсөлтийн цикл эхэлнэ гэж үзсэн. Дээрх гурван хувилбар ямар төсөөлөлд суурилсныг авч үзье.

**Дээд хувилбарын нөхцөл:** 2019 оны туршид экспортын орлогын гол хэсгийг бүрдүүлдэг нүүрсний үнэ төдийлөн ихээр буурахгүй, зөвхөн 2019 оны төгсгөлөөс буурна, харин зэсийн баяжмалын болон алтны үнэ нэмэгдэнэ гэж төсөөлсөн. Мөн БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ өмнөх 2018 оныхоос буурахгүй, харин ч бага зэрэг нэмэгдэнэ гэж үзэв. Дээр нь махны экспорт өснө гэж төсөөлсөн. Төгсгөлд нь уул уурхайн бус салбаруудад, тухайлбал, хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, барилгын салбарт мэдэгдэхүйц өсөлт гарна гэж тооцсон. 2019 оноос хойш 2021 он хүртэл эдийн засгийн өсөлт саарна. 2021 оноос гадаад зээлийн үндсэн төлбөрүүд эхэлнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт энэ үеэс эхлэн нэлээд буурна гэж үзсэн. Гэвч 2022 оноос "Оюу толгой" далд уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж, улсын төсөвт орох орлого эрс нэмэгдэнэ. Дотоодын ханган нийлүүлэгч компаниудын үйл ажиллагаа идэвхжиж, улам тэлнэ. 2022 оноос "Таван толгой" төсөл болон Гачууртын ордыг эзэмших зэрэг томоохон төслүүд жигдэрч, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ. 2023 онд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор ДНБ-ий өсөлтөд мэдэгдэхүйц нөлөөлнө гэж тооцов.


**Дунд хувилбарын нөхцөл:** 2019 оны туршид экспортын орлогын гол хэсгийг бүрдүүлдэг нүүрсний үнэ төдийлөн ихээр буурахгүй, зөвхөн 2019 оны төгсгөлөөс буурна, харин зэсийн баяжмалын болон алтны үнэ нэмэгдэнэ гэж төсөөлөв. 2019 онд БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ өмнөх 2018 оныхоос буурна гэж үзсэн. Уул уурхайн бус салбаруудад бага зэрэг өсөлт гарна гэж тооцов. 2019 оноос хойш 2021 он хүртэл эдийн

засгийн өсөлт саарна. 2021 оноос гадаад зээлийн үндсэн төлбөрүүд эхэлнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт энэ үеэс эхлэн нэлээд буурна. 2022 оноос Таван толгойн төсөл эрчимжинэ. 2023 онд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор ДНБ-ий өсөлтөд мэдэгдэхүйц нөлөөлнө гэж тооцов.

**Доод хувилбарын нөхцөл:** 2019 онд БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ өмнөх 2018 оныхоос буурна. Нүүрсний үнэ 2019 оны 2-р улирлаас үлэмж хэмжээгээр буурна. Уул уурхайн бус салбаруудад, тухайлбал, хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, барилгын салбарт төдийлөн их өсөлт гарахгүй гэж тооцов. 2019 оноос хойш 2021 он хүртэл эдийн засгийн өсөлт саарна. 2021-2023 оны хооронд гадаад зээлийн үндсэн төлбөрүүд хийгдэж, эдийн засгийн хямралтай байдал үүснэ. Мөн 2020 оны сонгуулиар засаглалын байдал урьд өмнөхөөсөө муудаж болзошгүй гэж үзсэн.

МУТХҮБ-2030-д ДНБ-ий 2015-2030 оны жилийн дундаж өсөлтийг 6,6 хувь байхаар тогтоосон. Сүүлийн 17 жилийн эдийн засгийн дундаж өсөлт 6,9 хувь гарсныг дээр тэмдэглэсэн билээ. Эндээс харахад МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн эдийн засгийн өсөлтийн дундаж хувь биелэгдэх боломжтой түвшин юм. Бидний төсөөлсөн ДНБ-ий 2018-2025 оны жилийн дундаж өсөлт доод хувилбараар 5,3 хувь, дунд хувилбараар 6,2 хувь, харин дээд хувилбараар 7 хувь гарсан.

**Зураг 6. ДНБ-ий суурь онтой (2000=1) харьцуулсан өсөлт, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зураг 2-оос харахад 2015 онд ДНБ дөнгөж 2,4 хувь, 2016 онд 1 хувь, харин 2017 онд 5,1 хувь өссөн байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 3 жилд эдийн засгаа жил тутам 6,6 хувьд хүргэж өсгөж чадаагүй билээ. Иймд, эдийн засгийг үлдсэн онуудад жилд дунджаар 6,6 хувиар нэмэгдүүлэхийн тулд өсөлтийн өмнөх алдагдлаа нөхөх хэрэгтэй бөгөөд ингэж байж зорилтот түвшиндээ ойртох юм. Ийм үндэслэлээр 2018-2025 оны эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг дундаж хувилбараар 6,2 хувь байна гэж үзсэн.


ДНБ-ий 2018-2025 оны төсөөллөөр ДНБ-ий хэмжээ 2000 оны түвшингээс 2020 онд 3 хувилбараар 3,8-4 дахин, 2025 онд 4,7-5,3 дахин нэмэгдэх боломжтой гэж гарсан. Зураг 3-т ДНБ-ий 2000-2017 оны гүйцэтгэлд үндэслэн тооцсон трендийн шугам 2025 онд ДНБ 2000 оныхоос 4,8 дахин өсөх боломжтойг харуулсан. Бид өмнөх онуудын бодит



өсөлтийн трендэд шинжилгээ хийх аргаар (Extrapolation of trends) энэхүү төсөөллийг гаргав.

Доорх зурагт ДНБ-ий 2018-2025 оны жил бүрийн хүрэх түвшинг 3 хувилбараар болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр харуулав.


**Зураг 7. ДНБ-ий 2018-2025 оны хүрэх түвшин, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

ДНБ-ий өсөлтийг төсөөлөхийн зэрэгцээ 2000-2017 оны ДНБ-ий дефляторт шинжилгээ хийж, үйлдвэрлэлийн хүрээний инфляцын өсөлтийг таамагласан.

**Зураг 8. ДНБ-ий дефляторын өсөлтийн тренд, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад ДНБ-ий дефляторын өөрчлөлтийг трендийн шулуун 96,4 хувийн түвшинд тайлбарлах чадвартай байна. Экстраполяцийн тооцооноос 2025 он гэхэд ДНБ-ий дефлятор 2000 оны түвшингээс 2,27 дахин өсөхөөр байна. Эндээс суурь 2000 онтой харьцуулсан ДНБ-ий дефляторын жил бүрийн өсөлт доорх байдалтай гарсан.

**Хүснэгт 11. ДНБ-ий дефляторын өсөлт, 2000 оны зэрэгцүүлэх үнээр**

(хувь)


	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>ДНБ-ий дефляторын өсөлт, 2000=1</b>	1.758	1.88	1.96	2	2.08	2.175	2.225	2.27

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо

Бид дээрх дефляторыг ашиглан ДНБ-ий 2018-2025 оны түвшинг оны үнээр 3 хувилбараар төсөөлж, доорх зурагт харуулав.

**Зураг 9. ДНБ, 2017-2025 оны үнээр**

(тэрбум төгрөг)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Бидний төсөөллөөр ДНБ-ий хэмжээ 2025 онд 57,8-65,4 их наяд төгрөгт хүрэхээр байна.

**2.1.2. Нэг хүн амд ногдох үндэсний нийт орлого**

МУТХҮБ-2030-д нэг хүнд ногдох ҮНО-ыг 17,500 америк долларт хүргэх зорилт дэвшүүлсэн.

**Хүснэгт 12. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО, ДБ-ны атласын аргаар**

(ам.доллар)

Он	Нэг хүн амд ногдох ҮНО	Жил бүрийн өсөлт (хувь)
2000	390	100
2001	400	102.6
2002	430	107.5
2003	480	111.6
2004	600	125
2005	690	115
2006	1000	144.9
2007	1290	129
2008	1670	129.5
2009	1630	97.6


2010	1870	114.7
2011	2310	123.5
2012	3160	136.8
2013	3770	119.3
2014	4280	113.5
2015	3870	90.4

Эх сурвалж: ДБ, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2002-2017.

Хүснэгтийн өгөгдлөөр энэ үзүүлэлтийн цаашдыг чиг хандлагын трендийг тооцож доорх зурагт харуулав.

Зургаас харахад өмнөх 16 жилийн өгөгдлийн чиг хандлагаар бол Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНО 2025 он гэхэд 6500 америк долларт дөхөж очихоор гарч байна. Трендийн шулуун шугам бидний төсөөллийг 90 хувь ( $R^2=0,8998$ ) нотлох чадвартайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, 2015-2025 оны хоорондох 10 жилд энэ үзүүлэлт 1,68 дахин буюу 68 орчим хувь нэмэгдэхээр байна. Энэ нь дээрх хугацаанд жил тутам 5,3 хувийн өсөлт үзүүлнэ гэсэн үг юм.

### Зураг 10. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО, ДБ-ны атласын аргаар (ам.доллар)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Энэ өсөлтөөр тооцвол манай орны нэг хүнд ногдох ҮНО 2030 онд 8400 америк долларт хүрч, 17500 ам.долларт хүргэх зорилт хэрэгжихгүй төлөвтэй байна.

#### 2.1.3. ДНБ-ий салбарын бүтцийн төсөөлөл

Улсын дүнгээр тооцсон ДНБ-ий 2018-2025 оны төсөөллийг оны болон зэрэгцүүлэх үнээр салбараар задлан тооцохдоо ҮСХ-оос боловсруулсан 2010-2016 оны салбар хоорондын тэнцлийн орцын шууд зардлын коэффициентийг ашиглав. Сүүлийн 7 жилийн салбар хоорондын тэнцлийн орцын шууд зардлын коэффициентүүд нь жил бүр өөрчлөгдөж ирсэн бөгөөд түүний цаашдын чиг хандлагыг харгалзан 2018-2025 оны төсөөллийг хийлээ.

Энэ нь үндсэн үнээр тооцсон ДНБ-ий хэмжээг салбарлах боломжийг олгодог. Гэтэл түүн дээр цэвэр татварыг нэмсэн зах зээлийн үнээр тооцсон ДНБ-ийг салбарлан задлахдаа өмнөх жилүүдийн салбарын бүтэц, түүнд гарсан өөрчлөлт болон үндсэн

үнээр тооцсон ДНБ-ий салбарын задаргаа зэргийг харгалзах үндсэн дээр 2018-2025 оны төсөөллийг хийв.

**Хүснэгт 13. ДНБ-ий 2018-2025 оны салбарын задаргааны төсөөлөл, оны үнээр,  
дунд хувилбараар**

(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>ДНБ</b>	31428.5	36029.9	39816.9	42660.9	46851.9	51931.3	56472	61647.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	3174.3	3494.9	3703	3754.2	3982.4	4362.2	4630.7	4931.8
Уул, уурхайн олборлолт	6851.4	7169.9	7565.2	7721.6	8199.1	8932.2	9430.8	9925.2
Боловсруулах үйлдвэрлэл	3268.6	3819.2	4300.2	4650	5200.6	5868.2	6494.3	7212.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	660	720.6	796.3	853.2	937	1038.6	1129.4	1232.9
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	157.1	216.2	238.9	256	328	363.5	451.8	493.2
Барилга	1392.9	1765.5	2150.1	2389	2717.4	3063.9	3388.3	3883.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	5342.8	6341.3	7167	7721.6	8527.1	9503.4	10390.9	11404.7
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1414.3	1549.3	1592.7	1621.1	1733.5	1713.7	1807.1	1911.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	345.7	432.4	477.8	554.6	609.1	675.1	734.1	863.1
Мэдээлэл, холбоо	722.9	792.7	836.2	895.9	983.9	1038.6	1073	1048
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	1602.9	1945.6	2269.6	2602.3	2951.7	3375.5	3840.1	4376.9

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2011.4	2341.9	2627.9	2858.3	3185.9	3583.3	3953	4376.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан ба техникийн үйл ажиллагаа	691.4	900.7	1035.2	1194.5	1358.7	1557.9	1694.2	1849.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	282.9	324.3	318.5	341.3	374.8	415.5	451.8	493.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	1351.4	1585.3	1791.8	1962.4	2108.3	2285	2428.3	2650.8
Боловсрол	1257.1	1477.2	1672.3	1834.4	2014.6	2285	2541.2	2774.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	565.7	684.6	756.5	853.2	937	1090.6	1185.9	1294.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	125.7	180.1	199.1	213.3	281.1	311.6	338.8	369.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	220	288.2	318.5	383.9	421.7	467.4	508.4	554.8

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Салбарын бүтцэд гарах төсөөллөөр 2025 он гэхэд ДНБ-д хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын эзлэх хувь багасаж, харин боловсруулах аж үйлдвэр, барилга, санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна.

**Хүснэгт 14. ДНБ-ий 2018-2025 оны салбарын бүтцийн төсөөлөл, оны үнээр, дунд хувилбараар (хувь)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>ДНБ</b>	100	100	100	100	100	100	100	100
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	10.1	9.7	9.3	8.8	8.5	8.4	8.2	8
Уул, уурхайн олборлолт	21.8	19.9	19.0	18.1	17.5	17.2	16.7	16.1
Боловсруулах үйлдвэрлэл	10.4	10.6	10.8	10.9	11.1	11.3	11.5	11.7

**БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ**

Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2.1	2	2	2	2	2	2	2
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.5	0.6	0.6	0.6	0.7	0.7	0.8	0.8
Барилга	4.4	4.9	5.4	5.6	5.8	5.9	6	6.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	17	17.6	18	18.1	18.2	18.3	18.4	18.5
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	4.5	4.3	4	3.8	3.7	3.3	3.2	3.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.1	1.2	1.2	1.3	1.3	1.3	1.3	1.4
Мэдээлэл, холбоо	2.3	2.2	2.1	2.1	2.1	2	1.9	1.7
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	5.1	5.4	5.7	6.1	6.3	6.5	6.8	7.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6.4	6.5	6.6	6.7	6.8	6.9	7	7.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан ба техникийн үйл ажиллагаа	2.2	2.5	2.6	2.8	2.9	3	3	3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.9	0.9	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	4.3	4.4	4.5	4.6	4.5	4.4	4.3	4.3
Боловсрол	4	4.1	4.2	4.3	4.3	4.4	4.5	4.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.8	1.9	1.9	2	2	2.1	2.1	2.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.4	0.5	0.5	0.5	0.6	0.6	0.6	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.7	0.8	0.8	0.9	0.9	0.9	0.9	0.9

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

ДНБ-ий зэрэгцүүлэх үнээр тооцсон салбарын задаргаа маш чухал үзүүлэлт юм.

Бидний төсөөллөөр 2018-2025 оны хооронд хамгийн хурдацтай хөгжих салбарт нэмэгдэл өртөг нь 1,7 дахин өсөх боловсруулах аж үйлдвэр, 2,2 дахин нэмэгдэх барилгын салбар, 2,1 дахин өсөх санхүү, даатгалын салбар, 1,7 дахин өсөх үл хөдлөх

хөрөнгийн салбар зэрэг орж байна.

**Хүснэгт 15. ДНБ-ий 2018-2025 оны салбарын задаргааны төсөөлөл, дунд хувилбараар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Цэвэр өсөлтөд салбаруудын хувь нэмэр			
									2018-2020		2020-2025	
									Тэрбум	хувь	Тэрбум	хувь
ДНБ	17911.1	19164.8	20314.7	21330.5	22525	23876.5	25380.7	27157.3	2403.7	100	6842.6	100
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	1809	1859	1889.3	1877.1	1914.6	2005.6	2081.2	2172.6	80.3	3.3	283.3	4.1
Уул, уурхайн олборлолт	3904.6	3813.8	3859.8	3860.8	3941.9	4106.8	4238.6	4372.3	-44.8	-1.9	512.5	7.5
Боловсруулах үйлдвэрлэл	1862.8	2031.5	2194	2325	2500.3	2698	2918.8	3177.4	331.2	13.8	983.4	14.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	376.1	383.3	406.3	426.6	450.5	477.5	507.6	543.1	30.2	1.3	136.9	2
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	89.6	115	121.9	128	157.7	167.1	203	217.3	32.3	1.3	95.4	1.4
Барилга	788.1	939.1	1097	1194.5	1306.4	1408.7	1522.8	1710.9	308.9	12.9	613.9	9
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	3044.9	3373	3656.7	3860.8	4099.5	4369.4	4670	5024.1	611.8	25.5	1367.5	20
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	806	824.1	812.6	810.6	833.4	787.9	812.2	841.9	6.6	0.3	29.3	0.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	197	230	243.8	277.3	292.8	310.4	329.9	380.2	46.8	1.9	136.4	2
Мэдээлэл, холбоо	412	421.6	426.6	447.9	473	477.5	482.2	461.7	14.7	0.6	35.1	0.5
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	913.5	1034.9	1157.9	1301.2	1419.1	1552	1725.9	1928.2	244.5	10.2	770.2	11.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1146.3	1245.7	1340.8	1429.1	1531.7	1647.5	1776.6	1928.2	194.5	8.1	587.4	8.6



**БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ**

Мэргэжлийн, шинжлэх ухаан ба техникийн үйл ажиллагаа	394	479.1	528.2	597.3	653.2	716.3	761.4	814.7	134.1	5.6	286.5	4.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	161.2	172.5	162.5	170.6	180.2	191	203	217.3	1.3	0.1	54.7	0.8
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	770.2	843.3	914.2	981.2	1013.6	1050.6	1091.4	1167.8	144	6	253.6	3.7
Боловсрол	716.4	785.8	853.2	917.2	968.6	1050.6	1142.1	1222.1	136.8	5.7	368.9	5.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	322.4	364.1	386	426.6	450.5	501.4	533	570.3	63.6	2.6	184.3	2.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	71.6	95.8	101.6	106.7	135.1	143.3	152.3	162.9	29.9	1.2	61.4	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	125.4	153.3	162.5	192	202.7	214.9	228.4	244.4	37.1	1.5	81.9	1.2

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрх хүснэгтэд харуулсан төсөөллөөс үзэхэд 2020-2025 оны хоорондох 5 жилд ДНБ-ий цэвэр өсөлтийн 20 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбар, 14,4 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 11,3 хувийг санхүү, даатгалын салбар, 9 хувийг барилгын салбар бий болгохоор байна.

**2.1.4. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтцийн төсөөлөл**

Макро түвшний хүрээний баланслуулах гол үзүүлэлтүүд нь ДНБ-ий эцсийн ашиглалтын элементүүд юм. Энд эцсийн хэрэглээ, хуримтлал, экспорт, импортын хэмжээний таамаглал орно. Салбар хоорондын тэнцлийн гарцын шууд зардлын коэффициентүүдэд шинжилгээ хийж, өөрчлөлтийн чиг хандлагын төсөөлөлд үндэслэн таамаглалыг 3 хувилбараар хийв.

**Хүснэгт 16. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, дээд хувилбараар (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ДНБ, оны үнээр	31428.5	36366.6	40568.1	43714.2	48372.4	53970.7	59352.3	65396.9
Эцсийн хэрэглээ	18228.5	22547.3	25963.6	29288.5	26121.1	31842.7	36798.4	41854
Хөрөнгийн нийт хуримтлал	13200	18183.3	19472.7	19671.4	24186.2	24286.8	24928	26158.7

Экспорт	18857.1	21092.6	21501.1	20982.8	26121.1	28064.8	29676.1	31390.5
Импорт (-)	18857.1	25456.6	26369.3	26228.5	28056	30223.6	32050.2	34006.4

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

**Хүснэгт 17. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, дунд хувилбараар**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ДНБ, оны үнээр	31428.5	36029.9	39816.9	42660.9	46851.9	51931.3	56472	61647.1
Эцсийн хэрэглээ	18228.5	22338.5	25482.8	28582.8	25300	30639.5	35012.7	39454.2
Төрийн байгууллагын хэрэглээ	2278.6	2837	3287.3	3744.3	3364.9	4105.7	4726.7	5365.8
Хөрөнгийн нийт хуримтлал	13200	18014.9	19112.1	19197.4	23426	23369.1	23718.3	24658.9
Экспорт	18857.1	20897.3	21102.9	20477.2	25300	27004.3	28236	29590.6
Импорт (-)	18857.1	25220.9	25881	25596.6	27174.1	29081.5	30494.9	32056.5

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Гурван хувилбараар хийсэн энэхүү төсөөлөл нь макро түвшний эрэлт, нийлүүлэлтийн балансыг хийх боломжийг олгоно.

**Хүснэгт 18. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, доод хувилбараар**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ДНБ, оны үнээр	31428.5	35794.2	39183.2	41582.2	45191.5	49618.3	53449.2	57802
Эцсийн хэрэглээ	18228.5	22192.4	25077.3	27860.1	24403.4	29274.8	33138.5	36993.3
Хөрөнгийн нийт хуримтлал	13200	17897.1	18807.9	18712	22595.8	22328.2	22448.7	23120.8
Экспорт	18857.1	20760.6	20767.1	19959.4	24403.4	25801.5	26724.6	27745
Импорт (-)	18857.1	25055.9	25469.1	24949.3	26211.1	27786.3	28862.6	30057

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Макро эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн ерөнхий тэнцвэрийг дараах байдлаар нэгтгэн харуулж болно.

(Нийт үйлдвэрлэл + Импорт) = (Завсрын хэрэглээ + Эцсийн хэрэглээ + Хуримтлал + Экспорт

Нийт үйлдвэрлэл ба импортын дүн нь эдийн засгийн нийт нөөцийн нийлүүлэлтийг илэрхийлдэг бол (Завсрын хэрэглээ) + (Эцсийн хэрэглээ) + (Хуримтлал) +(Экспорт) гэсэн нийлбэр нь нийт эрэлт буюу эдийн засгийн нөөцийн ашиглалтыг харуулдаг. Доорх хүснэгтэд энэхүү тэнцвэрийг харуулав.

**Хүснэгт 19. Эдийн засгийн макро түвшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийн төсөөлөл, оны үнээр, дундаж хувилбараар (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт үйлдвэрлэлт	61867.2	70646.9	77615.7	82676.2	90447.8	100060.3	108391.6	117647.2
Импорт	18857.1	25220.9	25881	25596.6	27174.1	29081.5	30494.9	32056.5
Нийт нийлүүлэлтийн дүн	80724.3	95867.8	103496.7	108272.8	117621.9	129141.9	138886.5	149703.7
Завсрын хэрэглээ	30438.6	34617	37798.9	40015.3	43595.8	48129	51919.6	56000.1
Эцсийн хэрэглээ	18228.5	22338.5	25482.8	28582.8	25300	30639.5	35012.7	39454.2
Хуримтлал	13200.5	18014.9	19112.1	19197.4	23426	23369.1	23718.3	24658.9
Экспорт	18857.1	20897.3	21102.9	20477.2	25300	27004.3	28236	29590.6
Нийт эрэлтийн дүн	80724.3	95867.8	103496.7	108272.8	117621.9	129141.9	138886.5	149703.7


Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Нийт үйлдвэрлэл, импортын дүн болох нийт нийлүүлэлтийн хэмжээ нийт эрэлтийн дүнтэй балансалж байгааг дээрх хүснэгтээс харж болно.

**2.1.5. Инфляцын төсөөлөл**

Юуны өмнө 2000-2017 оны инфляцийн бодит дүр төрхийг шинжилсэн.


**Зураг 11. Инфляцын 2000-2017 оны жил бүрийн өсөлт (хувь)**



Өнгөрсөн 17 жилийн инфляцын төлөв байдлаас харахад инфляцын түвшин тогтворгүй өсч, буурч ирсэн бөгөөд эдийн засгийн өсөлт өндөр байсан жилүүдэд инфляцын түвшин мөн өндөр байсан хандлага ажиглагдаж байна.

ДНБ-ий болон инфляцийн өсөлтийн чиг хандлагыг доорх зурагт харуулав.


**Зураг 12. ДНБ болон инфляцын суурь 2000 онтой харьцуулсан өсөлт (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад 2000-2007 оны хооронд ДНБ болон инфляцийн өсөлт ойролцоо байсан бол 2008 оноос эхлээд инфляцын өсөлт ДНБ-ий өсөлтөөс давамгайлсан хурдтай нэмэгджээ.

**Зураг 13. ДНБ болон инфляцын корреляцийн хамаарлын цэгэн тархалт (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад ДНБ болон инфляцын өсөлтийн хооронд корреляцийн шууд хамаарал байгаа нь тодорхой байна. Хамаарлыг илэрхийлсэн шулуун шугам энэхүү хамаарлыг 95 хувийн магадлалтай тайлбарлах чадвартай байгааг детерминацын коэффициент илэрхийлж байна. Корреляцийн коэффициентийг тооцоход 0,995 гарч энэ 2 үзүүлэлт маш хүчтэй хамааралтай болох нь тогтоогдсон. Энэхүү хүчтэй хамаарлыг ашиглан бид инфляцын ойрын 8 жилийн төсөөллийг гаргав. Стандарт хазайлтыг тооцож,

дээрх хамаарлыг илэрхийлсэн шулуун шугам доорх тэгшитгэлээр илэрхийлэгдэж байгааг тогтоосон.


$$Y=1,415826X-0,41586$$

Энд: X - ДНБ-ий өсөлт

Y - инфляцын өсөлт

Бидэнд нэгэнт 2018-2025 оны ДНБ-ий 2000 онтой харьцуулсан өсөлт зэрэгцүүлэх үнээр байгаа тул түүнийг X хэмжигдэхүүнд орлуулан дээрх тэгшитгэлээс инфляцын 2018-2025 оны суурь 2000 онтой харьцуулсан өсөлтийг гаргасан. Эндээс мөн 2018-2025 оны инфляцийн жил бүрийн өсөлтийг тооцох боломжтой. Үр дүнг доорх зургуудад харуулав.


**Зураг 14. Инфляцын өсөлтийн 2000-2017 оны гүйцэтгэл болон 2018-2025 оны төсөөлөл, 2000 оны зэрэгцүүлэх үнээр (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад инфляцын түвшин 2017 онд 2000 оны түвшингээс 3,9 дахин өндөр байсан бол 2020 онд 4,8 дахин, харин 2025 онд 6,6 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Энэ бүх өсөлт манай ДНБ-ий өсөлттэй шууд уялдаатай юм.

**Зураг 15. 2010-2017 оны инфляцын жил бүрийн өсөлтийн гүйцэтгэл болон 2018-2025 оны төсөөлөл (хувь)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.


Бидний төсөөллөөр ДНБ-ий огцом өсөлт, бууралт гарахгүй нөхцөлд инфляцын өсөлт өмнөх онуудынхаас харьцангуй тогтвортой, 2018-2025 онд жил бүр 5,2-8,2 хувийн хооронд хэлбэлзэх төлөвтэй байна.

### 2.1.6. Хөрөнгө оруулалтын 2018-2025 оны төсөөлөл

Хөрөнгө оруулалтын төсөөллийг ДНБ болон хөрөнгө оруулалтын хоорондын хамааралд тулгуурлан хийсэн.

Хөрөнгө оруулалт нь ДНБ-ий өсөлтөд ямар хамааралтай байгааг доорх хамаарлын цэгэн тархалтын графикаар харуулав.

**Зураг 16. Хөрөнгө оруулалт болон ДНБ-ий хамаарлын цэгэн тархалт**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Шулуун шугаман хамаарлын тренд 80 хувийн тайлбарлах чадвартайг харуулж байна. Корреляцийн коэффициентийг тооцоход 0,896 гарч энэ 2 үзүүлэлт хүчтэй

хамааралтай болох нь тогтоогдсон. Энэхүү хүчтэй хамаарлыг ашиглан бид хөрөнгө оруулалтын ойрын 8 жилийн төсөөллийг гаргав.

Хамаарлын шулуун шугаман тэгшитгэл  $Y=1916,728+2,357319X$  гэсэн утгатай параметруудээс илэрхийлэгдэж байгааг тооцсон. Эндээс бид  $Y$  нь үр дүнгийн үзүүлэлт болох ДНБ-ий утга тул хөрөнгө оруулалтыг дээрх тэгшитгэлээс дараах хэлбэрээр  $X=(Y-1916,728)/2,357319$  тооцсон. Тооцооны үр дүнг 3 хувилбараар доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 20. Хөрөнгө оруулалтын 2018-2025 оны төсөөлөл, оны үнээр, 3 хувилбараар**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээд хувилбар</b>								
<b>ДНБ, оны үнээр</b>	31487.6	36366.6	40568.1	43714.2	48372.4	53970.7	59352.3	65396.3
<b>Хөрөнгө оруулалт</b>	12544.28	14614.02	16396.34	17730.95	19707	22081.86	24364.77	26928.96
<b>Дунд хувилбар</b>								
<b>ДНБ, оны үнээр</b>	31487.6	36029.9	39816.9	42660.9	46851.9	51931.3	56472	61647.1
<b>Хөрөнгө оруулалт</b>	12544.28	14471.1	16077.6	17284.1	19061.9	21216.6	23142.8	25338.2
<b>Доод хувилбар</b>								
<b>ДНБ, оны үнээр</b>	31487.6	35794.2	39183.2	41582.2	45191.5	49618.3	53449.2	57802
<b>Хөрөнгө оруулалт</b>	12544.28	14371.18	15808.84	16826.51	18357.63	20235.53	21860.63	23707.14

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Тооцооноос харахад 2025 онд хөрөнгө оруулалтын хэмжээ 23,7-26,9 тэрбум төгрөгийн хооронд байна. Энэ бол 90 хувийн магадлалтай төсөөлөл гэдэг нь корреляцийн хүчний хэмжээнээс харагдаж байна.

**2.1.7. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төсөөлөл**

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төсөөлөл нь макро эдийн засгийн хүрээний нэг чухал хэсэг болдог. Сангийн яам төсвийн хүрээний мэдэгдэлдээ 2018-2019 оны төсвийн орлого, зарлагын таамаглалаа гаргажээ.

Эдийн засгийн өсөлт, тэлэлт болон нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг доорх зургуудад харуулав.



**Зураг 17. ДНБ болон нэгдсэн төсвийн зарлагын жил бүрийн өсөлт, оны үнээр (хувь)**



Эх сурвалж: ҮСХ-ны статистикийн эмхэтгэл, 2016, [www.1212.mn](http://www.1212.mn).

Зургаас харахад сүүлийн 12 жилд нэгдсэн төсвийн нийт зарлага эдийн засаг тэлж өсөх үед ихээхэн нэмэгдэж, эдийн засгийн өсөлт буурах үед багасаж ирсэн чиг хандлага ажиглагдаж байна. Мөн зарим онуудад, тухайлбал, 2011, 2016 онуудад нэгдсэн төсвийн зарлага ДНБ-ий өсөлтөөс нэлээд өндөр байсан нь анхаарал татаж байна.

**Зураг 18. ДНБ болон нэгдсэн төсвийн зарлагын суурь онтой харьцуулсан өсөлт, оны үнээр, 2005 оны зэрэгцүүлэх үнээр (хувь)**



Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2016. [www.1212.mn](http://www.1212.mn).

2005 оноос хойш нэгдсэн төсвийн зарлага ДНБ-ий өсөлтөөс илүү хурдтай нэмэгдэж ирсэн зохисгүй хандлага бий болжээ. 2017 онд ДНБ-ий нэрлэсэн хэмжээ 2005 оныхоос 9,2 дахин нэмэгдсэн байхад нэгдсэн төсвийн нийт зарлага 11,7 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл, манай орны төсөв эдийн засгийнхаа өсөлтөөс илүү хурдтай тэлж иржээ.


**Хүснэгт 21. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын хэмжээ, оны үнээр**  
(тэрбум төгрөг)

	Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн	Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ	ДНБ (тайлант оны үнээр)
2000	351	429.6	1224.1
2001	439.2	489.7	1391.9
2002	477	548.6	1550.6
2003	553.8	615.7	1829.1
2004	713.1	752.4	2361.2
2005	837.8	764.5	3041.4
2006	1360.4	1237	4027.6
2007	1880.4	1747.3	4956.6
2008	2170.3	2466.7	6555.64
2009	1993.9	2336.6	6590.6
2010	3078.4	3076.2	9756.6
2011	4468.2	4997	13173.8
2012	4981.7	6017.8	16688.4
2013	5986.9	6164.6	19174.2
2014	6316.5	7144.5	22227.1
2015	5983.3	7137.9	23150.4
2016	5852	9519.9	23942.9
2017	7922.5	8981	27895.5
2018	7231.4	9651.5	31428.5 /таамаг/
2019	9676.5	11589.8	36029.9 /таамаг/

Эх сурвалж: ҮСХ, Сангийн яамны төсвийн хүрээний мэдээгдэл.

Хүснэгтийн өгөгдлийг график дүрслэлд оруулан 2025 он хүртэлх чиг хандлагын трендийг доорх зурагт харуулав.


**Зураг 19. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, цаашдын чиг хандлага**  
(тэрбум төгрөг)



Эх сурвалж: ҮСХ, Сангийн яамны төсвийн хүрээний мэдээгдэл.

Зургаас харахад нэгдсэн төсвийн орлого, зарлага хоорондоо тодорхой хэмжээний хамааралтай байж болохоор байна. Энэхүү хамаарлыг доорх зурагт харуулав.

**Зураг 20. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын хамаарал**  
(тэрбум төгрөг)




Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Хамаарлын цэгэн дүрслэл болон түүнийг илэрхийлсэн шулуун шугамын детерминацын коэффициент 0,96 байгаа нь хамаарлыг тайлбарлах чадвар өндөр байгааг харуулж байна.

Нөгөө талаас, улсын нэгдсэн төсвийн орлого нь ДНБ-ий хэмжээтэй шууд хамааралтай гэсэн таамаглал дэвшүүлж шалгая. Дээрх хүснэгтийн өгөгдлүүдээр хамаарлын цэгэн дүрслэлийг доорх зурагт харуулав.

**Зураг 21. ДНБ болон нэгдсэн төсвийн орлогын хамаарал**  
(тэрбум төгрөг)




Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Хамаарлын цэгэн дүрслэл болон түүнийг илэрхийлсэн шулуун шугамын детерминацын коэффициент 0,98 байгаа нь хамаарлыг тайлбарлах чадвар өндөр, хүчтэй шууд хамааралтай болохыг нотолж байна. Стандарт хазайлт болон бусад шаардлагатай өгөгдлүүдээс хамаарлыг илэрхийлсэн шугаман тэгшитгэл  $Y=224,93+0,271X$  болохыг гарган авсан. Энэхүү тэгшитгэлийн Х-нөлөөлөгч хүчин зүйлд ДНБ-ий оны үнээр, дунд хувилбараар тооцсон 2020-2025 оны түвшингүүдийг орлуулснаар бид улсын нэгдсэн төсвийн орлогын 2020-2025 оны түвшинг тооцоолж гаргасан. Өөрөөр хэлбэл, ДНБ болон нэгдсэн төсвийн орлогын хоорондох хүчтэй хамаарлыг ашиглан 2020-2025 оны тоцооллыг хийв. Дээр бид нэгдсэн төсвийн орлого, зарлага хоорондоо мөн хүчтэй хамааралтай болохыг харуулсан тул дараагийн шатанд энэ 2 өгөгдлийн хамаарлаас нэгдсэн төсвийн зарлагын 2020-2025 оны төсөөллийг хийсэн.

Нэгдсэн төсвийн орлого, зарлага хоёрын хоорондын хамаарлын хүчийг илэрхийлсэн корреляцийн коэффициент 0,0975 гарсан. Энэ бол хангалттай хүчтэй хамаарлыг илэрхийлж байна. Дээр дурдсанаар хамаарлын шугаман тэгшитгэлийг тооцоход  $Y=1,2181X-1283,97$  гэж гарав. Энд Х- хэмжигдэхүүнээр нэгдсэн төсвийн орлогын 2020-2025 оны төсөөлсөн түвшинг авч тооцоолж, 2020-2025 оны нэгдсэн төсвийн зарлагын төсөөлсөн түвшинг гарган авсан. Ийнхүү нэгдсэн төсвийн орлого, зарлагын 2020-2025 оны түвшинг доорх зурагт харуулснаар урьдчилан тооцсон үр дүнд хүрэв.


**Зураг 22. Улсын нэгдсэн төсвийн 2017-2025 оны орлого, зарлага, тэнцэл**  
(тэрбум төгрөг)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Энэхүү тооцоог шалгах зориулалтаар ДНБ-д нэгдсэн төсвийн орлого, зарлагын эзлэх хувийг тооцож доорх зурагт харуулав.

**Зураг 23. ДНБ-д нэгдсэн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

МУТХҮБ-2030-д төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагыг (улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор) 2020 онд 35 хувь, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлсэн билээ. Манай тооцоогоор 2025 онд ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хувь 31,4 хувь болж, 2030 онд 30 хувьд хүргэх зорилт биелэгдэж болохоор байна.

### 2.1.8. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн төсөөлөл

Макро хүрээний төсөөллийн төгсгөлд нь нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн 2018-2025 оны төсөөллийг гаргав. Бидэнд ДНБ-ий 2018-2025 онд хүрэх түвшний төсөөлөл, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, түүнчлэн ажиллагсдын тооны төсөөлөл дээрх онуудаар байгаа тул нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн хүрэх түвшинг төсөөлөх хялбар байсан.


**Хүснэгт 22. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн 2018-2025 оны түвшний төсөөлөл, 3 хувилбараар**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Доод хувилбар</b>								
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (тэрбум төгрөг)	17877.4	19128.8	20085.3	20888.7	21828.7	22920.1	24134.9	25583
Ажиллагчдын тоо	1288.1	1308.8	1330.9	1376.1	1396.7	1413.2	1442.6	1471.9
Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)	13878.6	14615.8	15091.5	15179.9	15628.6	16218.8	16729.8	17380.5
<b>Дунд хувилбар</b>								
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (тэрбум төгрөг)	17877.4	19307.6	20562.6	21611.3	22821.5	24190.8	25714.9	27514.9
Ажиллагчдын тоо	1305.9	1331.8	1370.2	1433	1466.2	1499.8	1547.6	1597.6

<b>Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)</b>	13689.7	14497.1	15006.7	15081	15565.5	16129	16615.4	17223
<b>Дээд хувилбар</b>								
<b>ДНБ, 2010 оны зэргэцүүлэх үнээр (тэрбум төгрөг)</b>	17877.4	19432.8	20793.1	21957.5	23362.7	24928.1	26797.7	28941.5
<b>Ажиллагчдын тоо</b>	1312.8	1353.4	1407.4	1476.6	1514	1556.9	1615	1675.9
<b>Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)</b>	13617.6	14358.2	14773.8	14870.1	15431.4	16011	16592.7	17269.7

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

**Зураг 24. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж, дундаж хувилбар (мянган төгрөг)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Бидний тооцоолсноор 2025 онд нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн түвшин дунд хувилбараар 17,2 сая төгрөгт хүрч, 2017 оныхоос 2,6 хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

## **2.2. Сонгосон салбарын 2018-2025 оны хөгжлийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл, урьдчилсан тооцоо**

Макро эдийн засгийн хүрээг тодорхойлсноор дээрээс төлөвлөх үе шат дуусч, доороос төлөвлөх үе шат эхэлнэ. Доороос төлөвлөх үе шатанд салбарын яам, агентлагууд, мэргэжлийн холбоод хамтран салбарынхаа үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн дунд хугацааны төлөвлөгөөг томоохон аж ахуйн нэгж, компаниудын бизнесийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулах ёстой. Харамсалтай нь өнөөдөр төлөвлөлтийн ийм тогтолцоо бүрдээгүй байгаа нь Эрчим хүч, Уул уурхай, Хүнд үйлдвэрийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамдаас харагдаж байна. Бид энэ 3 салбарыг сонгон доороос төлөвлөлт хийх оролдлого хийсэн боловч эдгээр яамдад урагш харж, салбарынхаа үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг дунд хугацааны хувьд төлөвлөсөн, төсөөлөл огт алга байна.

### 2.2.1. Эрчим хүчний салбар

Эрчим хүчний салбарын 2018-2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл:

Эрчим хүчний салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо МУТХҮБ-2030 болон Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, эрчим хүчний салбарын тэргүүлэх чиглэл болон салбарын яам, агентлагуудын мэргэжилтнүүдийг оролцуулан салбарын хөгжлийн тулгамдсан асуудлаар хийсэн хэлэлцүүлэгт тулгуурлан тодорхойлсон. Эдгээрийн үр дүнд 2020-2025 оны салбарын дунд хугацааны 6 тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах;
2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох;
3. Санхүү, хөрөнгө оруулалтын чадавхыг бэхжүүлэх;
4. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах;
5. Гадаад, дотоод хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
6. Тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах.

МУТХҮБ 2030-д 2025 он гэхэд Монгол Улс эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах, нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25 хувьд хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах, өрхийг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр 100 хувь хангах, гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг 100 хувь дотоодын эх үүсвэрээс хангах зэрэг зорилтууд тусгагдсан.

Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газар 2018-2020 он хүртэл хэрэгжүүлэх “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын баримт бичигтээ Өмнөговь аймгийн Цогтцэций суманд “Таван толгой” 450 Мвт хүчин чадалтай цахилгаан станц барих, “Баян-Овоогоос Ханбогд” чиглэлийн 2 хэлхээ 220 Квт цахилгаан дамжуулах 138 км урттай шугам, V цахилгаан станц болон Эгийн голын усан цахилгаан станц барих зэрэг томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлүүлэх зорилтуудыг тавьсан.

Дээрх төсөл, арга хэмжээнүүд хэрэгжинэ гэж үзээд энэ салбарын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг дараах байдлаар тооцоолон төсөөллөө. Энэ нь төлөвлөлтийн зарчмын дагуу салбарын түвшинд доороос дээш хийсэн төсөөлөл болно.



**Хүснэгт 23. Эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний төсөөлөл, 3 хувилбараар**  
(тэрбум төгрөг)

		2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Цахилгаан эрчим хүч (сая Квт)</b>	Доод	4967.6	5189.7	5371.3	5557.3	5717.7	5893	5950.5	6439.6
	Дунд	6209.5	6487.2	6714.2	6946.7	7147.2	7366.2	7438.1	8049.6
	Дээд	7948.1	8303.6	8594.1	8891.7	9148.4	9428.7	9520.8	10303.4
<b>Дулааны эрчим хүч (мян, Ккл)</b>	Доод	9314.7	9647.2	10079.2	10429.4	10684.1	11146	1122.3	10960.8
	Дунд	11643.4	12059	12599.1	13036.8	13355.2	13932.5	14026.6	13701
	Дээд	14903.5	15435.5	16126.8	16687.1	17094.6	17833.6	17954.1	17537.3
<b>Молибдены баяжмал (тн)</b>	Доод	49.9	50.3	50.5	49.7	48.2	45.4	43.6	50.2
	Дунд	62.4	62.9	63.1	62.2	60.2	56.7	54.6	62.7
	Дээд	79.9	80.5	80.7	79.6	77.1	72.6	69.8	80.3
<b>Түгээсэн ус (сая М³)</b>	Доод	49.9	50.3	50.5	49.7	48.2	45.4	43.6	50.2
	Дунд	62.4	62.9	63.1	62.2	60.2	56.7	54.6	62.7
	Дээд	79.9	80.5	80.7	79.6	77.1	72.6	69.8	80.3
<b>Нэг хүнд ногдох дулааны эрчим хүч (Ккал)</b>	Доод	49.9	50.3	50.5	49.7	48.2	45.4	43.6	50.2
	Дунд	62.4	62.9	63.1	62.2	60.2	56.7	54.6	62.7
	Дээд	79.9	80.5	80.7	79.6	77.1	72.6	69.8	80.3

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрх гол нэр төрлийн бүтээгдэхүүний төсөөлөл дээр үндэслэн эрчим хүчний салбарын 2020-2025 оны нийт үйлдвэрлэлийн төсөөллийг дараах байдлаар тооцооллоо.

**Хүснэгт 24. Эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл, оны үнээр**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээд хувилбар</b>	546.6	606.2	672.3	745.6	826.8	917	1016.9	1127.7
<b>Дунд хувилбар</b>	541.7	595.3	654.3	719	790.2	868.5	954.4	1048.9
<b>Доод хувилбар</b>	531.8	573.9	619.2	668.1	720.9	777.8	839.3	905.6

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Бидний төсөөллийн дунд хувилбараар 2025 онд салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ оны үнээр 1048,9 тэрбум төгрөгт хүрнэ. Энэ тооцоог уг нь салбарын яам доороос хийх ёстой бөгөөд гарсан үр дүнг макро хүрээний тооцоотой харьцуулан уялдуулах шаардлагатай.

Макро түвшинд дээрээс доош тооцоолсон төсөөллийг тухайн салбарын доороос дээш тооцоолсон төсөөлөлтэй дараах байдлаар харьцуулж харуулав.

**Хүснэгт 25. Эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээрээс төлөвлөсөн төсөөлөл</b>	660	720.6	796.3	853.2	937	1038.6	1129.4	1232.9
<b>Доороос хийсэн тооцоо, дунд</b>	541.7	595.3	654.3	719	790.2	868.5	954.4	1048.9
<b>Зөрүү</b>	-118.3	-125.3	-142.1	-134.2	-146.8	-170.2	-175	-184

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрээс болон доороос хийсэн төлөвлөлтийн үр дүн мэдээж яг таарахгүй бөгөөд статистикийн зөрүү гэж нэрлэнэ.

**2.2.2. Хөдөө аж ахуйн салбар**

Хөдөө аж ахуйн салбарын 2018-2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл:

Хөдөө аж ахуйн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо МУТХҮБ-2030, Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тэргүүлэх чиглэл болон салбарын яам, агентлагуудын мэргэжилтнүүдийг оролцуулан явуулсан мал аж ахуйн болон газар тариалангийн салбарын хөгжлийн тулгамдсан асуудлаарх хэлэлцүүлэг зэрэгт тулгуурлав. Уг хэлэлцүүлгээс шийдвэрлэх бодлогын зорилтуудыг шинээр тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэхийн зэрэгцээ тэдгээрээс эхний 5-6 эрэмбийн зорилтуудыг дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд сонгон авсан.

Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд бэлчээрийн ашиглалт ба нөхөн сэргээлтийг тэнцвэржүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах;
2. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулж, малыг эрүүлжүүлэх;
3. Мал үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулж, малын ашиг шимийг нэмэгдүүлж, тэсвэрт чанарыг хадгалах;
4. Мал аж ахуйн ба туслах аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөн хөгжүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлж, малчид ба аж ахуй эрхлэгчдийн орлогыг өсгөн, мал аж ахуй ба туслах аж ахуйн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;
5. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд мал аж ахуйн салбарын тогтолцоо, засаглал, хууль эрх зүйг сайжруулах.

Газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд газрын ашиглалт ба хөрсний нөхөн сэргээлтийг тэнцвэржүүлж, хөрсний доройтлыг бууруулан газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг багасган тогтвортой хөгжлийг хангах;

2. Үр, бордоо, ургамал хамгаалах бодисын чанар, хяналтыг сайжруулж, газар тариалангийн бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байдлыг хадгалж, хүн амыг эрүүл хүнсээр хангах;
3. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүс нутаг, орц болон бүтээгдэхүүний төрөл ба хэмжээ, техник, технологийг оновчтой тодорхойлон бүтээмжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах;
4. Газар тариалангийн бүтээгдэхүүний ба орцын зах зээлийг хөгжүүлж, технологи, бүтээмжийг дээшлүүлэн тариаланчид ба газар тариалангийн салбарын орлогыг нэмэгдүүлэх;
5. Газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд тус салбарын тогтолцоо, хууль эрх зүйг сайжруулах.

Дээрх тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” дараах зорилтуудыг үндэслэл болгосон. Үүнд:

- Уламжлалт мал аж ахуй зонхилно;
- Газар тариалангийн бүс нутгийг тогтооно;
- Хот суурин газрыг түшиглэн эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлнэ;
- Хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ;
- Экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;
- Эрүүл аюулгүй хүнсээр дотоодын хэрэгцээг хангана.

Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн үндсэн 3 тулгуур салбар нь хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл болон уул уурхайн салбар юм. Хөдөө аж ахуйн салбар, нэн ялангуяа мал аж ахуй нь Монгол Улсын эдийн засагт том үүрэг гүйцэтгэсээр ирсэн уламжлалт үндсэн салбар юм.

**Хүснэгт 26. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын нийт үйлдвэрлэл, оны үнээр (тэрбум төгрөг)**

2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1691.7	1737.4	1752.4	2053.7	2569.4	3445	4099.1	4323	4151.7

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017, [www.1212.mn](http://www.1212.mn).

Энэхүү хүснэгтээс харахад хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын нийт үйлдвэрлэл 2016 онд буурсан, харин өмнөх жилүүдэд нь байнга өсөх хандлагатай байжээ.

Энэ салбарын нийт үйлдвэрлэл 2016 онд буурсан нь малын тооны хэт өсөлт ба зах зээлийн нөхцлөөс шалтгаалсан түүхий эдийн үнийн уналт болон махны үйлдвэрлэл өмнөх оныхтой харьцуулахад нядалгааны жингээр 48,3 мянган тонн, арьс, шир 1,2 сая ширхэгээр багассантай холбоотой юм.

Хөдөө аж ахуйн салбар нь 2017 оны байдлаар нийт 114,8 сая га эдэлбэр газартай, үүний дотор бэлчээр, хадлангийн газар 112,1 сая га, тариалангийн ба атаршсан газар 1,3 сая га ба барилга байгууламжийн газар 0,1 сая га байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт буцалтгүй тусламжийн 17, зээлийн 1, техникийн туслалцааны 2 төсөл тус тус хэрэгжиж байна.

Энэ салбарт хэрэгжиж байгаа 10-аад хөтөлбөр “Монгол мал” хөтөлбөр, “Малын эрүүл мэнд” хөтөлбөр, “Ноолуур” хөтөлбөр, “Жимс, жимсгэнэ” хөтөлбөр, “Хүнсний ногоо” хөтөлбөр гэх мэт) ба боловсруулж байгаа 8 хөтөлбөр (Монгол малчин хөтөлбөр, Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр гэх мэт) байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын 2018-2025 оны хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг хийхдээ сүүлийн 10 жилийн (2008-2017 оны) хөгжил, өөрчлөлтийн чиг хандлагыг тооцож, дунд хугацааны төсөөлөлдөө гол үндэслэл болгов. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэл, МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн бодлогын зорилтууд болон үндсэн үзүүлэлтүүдийн 2025 онд хүргэхээр дэвшүүлсэн зорилтот түвшин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тодорхойлсон салбарын тэргүүлэх чиглэл зэргийг харгалзан үзсэн. Дунд хугацаанд төсөөлөл хийхэд эдийн засаг, нийгэм, байгаль орчин, цаг уурын урьдчилан тааварлаагүй эерэг ба сөрөг гэнэтийн өөрчлөлтүүд болон төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл нөлөөлж болох учир дунд хугацааны төлөвлөгөөний гол үзүүлэлтүүдийг чиг хандлагаас доогуур буюу доод, чиг хандлагын дагуу буюу дунд, чиг хандлагаас дээгүүр буюу дээд гэсэн 3 хувилбараар авч үзлээ.

**Хүснэгт 27. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл, оны үнээр (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээд хувилбар</b>	4941.1	5335.8	5730.5	6125.2	6519.9	6914.6	7309.3	7704
<b>Дунд хувилбар</b>	4093.8	4297.9	4531.7	4784.3	5050.4	5326.7	5610.9	5901.7
<b>Доод хувилбар</b>	5788.4	6373.7	6929.4	7466.1	7989.4	8502.6	9007.7	9506.3

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Макро түвшинд дээрээс доош тооцоолсон төсөөллийг тухайн салбарын доороос дээш тооцоолсон төсөөлөлтэй дараах байдлаар харьцуулж харуулав.

**Хүснэгт 28. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээрээс төлөвлөсөн төсөөлөл</b>	4668.1	5139.6	5445.5	5520.8	5856.5	6415	6911.5	7360.9
<b>Доороос хийсэн тооцоо (Дунд)</b>	4941.1	5335.8	5730.5	6125.2	6519.9	6914.6	7309.3	7704
<b>Зөрүү</b>	-273	-196.2	-285	-604.4	-663.4	-499.6	-397.8	-343.1

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

### **2.2.2.1. Мал аж ахуй**

Мал аж ахуй бол манай улсын хөдөө аж ахуйн гол салбар бөгөөд эдийн засагт том үүрэг гүйцэтгэдэг. 2017 оны байдлаар манай улс 66,2 сая малтай байсан бөгөөд мал аж ахуйн салбар оны үнээр 3,7 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ДНБ-ий 10,6 хувь, экспортын орлогын 8,4 хувийг бүрдүүлжээ. Нийт ажиллах хүчний 30 хувь нь тус салбарт ажиллаж, 2017 онд нядалгааны жингээр 426,1 мянган тонн мах, 919,5 сая литр сүү, 30,6 мянган тонн хонины ноос, 10,2 мянган тонн ноолуур, 1,9 мянган тонн тэмээний ноос, 14,5 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэв.

#### **Хүснэгт 29. Мал аж ахуйн нийт үйлдвэрлэл, оны үнээр, (тэрбум төгрөг)**

2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1377.1	1307.7	1353.9	1585.3	2114.8	2937.6	3468.4	3728.7	3496

Эх сурвалж: ҮСХ, статистикийн эмхэтгэл, 2017, [www.1212.mn](http://www.1212.mn).

Энэ хүснэгтээс харахад мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл 2016 онд буурч, түүнээс өмнөх жилүүдэд байнга өсгөж иржээ.

Уламжлалт мал аж ахуй ба боловсруулах үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого оновчгүй бөгөөд түүний хэрэгжилт хангалтгүй байснаас энэ салбарт байгаль, ус, бэлчээрийн доройтол, малын өвчлөл, малын үржил селекци ба ашиг шим, тэсвэрт чанарын бууралт, малчдын орлогын бууралт, ядуурал, өр зээл гэх мэт нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон бэрхшээл тулгарчээ.

Мал аж ахуйн салбарын болон улс орны тогтвортой хөгжилд хамгийн ноцтой сөрөг нөлөө үзүүлж буй тулгамдсан асуудлын нэг нь малын өвчлөл юм.

#### **Хүснэгт 30. Халдварт өвчин гарсан сум, давхардсан тоогоор (сумын тоо)**

Он	2012	2013	2014	2015	2016
Үзүүлэлт	448	756	991	860	598

Хүснэгтээс харахад халдварт өвчин гарсан сумын тоо давхардсан тоогоор 2012 оноос 2014 он хүртэл өссөн бол харин 2014 оноос хойш буурах болжээ.

Уг асуудлыг төр засаг анхааралдаа авч 2017 онд УИХ-аас "Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийг баталж гаргасан ба Засгийн газар 2018 оны 12 дугаар тогтоолоор "Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр баталжээ. Улсын мал эмнэлгийн газрыг 2018 онд шинээр байгуулав.

Мал аж ахуйн салбарын бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн зорилтуудыг сайн, дунд, тааруу хэрэгжүүлсэн нөхцөлөөс болон өмнөх хугацааны өсөлтийн хандлагаас дараах төсөөллийг гаргалаа.

#### **Хүснэгт 31. Мал аж ахуйн нийт үйлдвэрлэлийн төсөөлөл, оны үнээр (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дээд хувилбар	4728.6	4977.9	5226.7	5475	5722.8	5970.2	6217.3	6464

<b>Дунд хувилбар</b>	3935.5	4160.2	4384.9	4609.6	4834.3	5059.1	5283.7	5508.4
<b>Доод хувилбар</b>	3142.4	3342.5	3543.1	3744.3	3945.8	4147.8	4350.2	4552.9

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

### **2.2.2.2 Газар тариалан**

Газар тариалангийн салбарт 2017 онд 15985 өрх, 1447 аж ахуйн нэгж ажиллаж, нийт 524,3 мянган га талбайд тариалалт, 370,7 мянган га талбайд уринш хийж, 231,4 мянган тонн улаан буудай, 1,7 мянган тонн арвай, 3,5 мянган тонн овъёос, 121,8 мянган тонн төмс, 82,1 мянган тонн хүнсний ногоо, 47,9 мянган тонн тэжээлийн ургамал, 13,9 мянган тонн техникийн ургамал, 1,5 мянган тонн жимс, жимсгэнэ хурааж, урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 552,2 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

#### **Хүснэгт 32. Газар тариалангийн нийт үйлдвэрлэл, оны үнээр (тэрбум төгрөг)**

2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
314.6	429.6	461.7	548.4	583	520.1	639.1	532.5	655.6

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2005, 2010, 2017, [www.1212.mn](http://www.1212.mn).

Хүснэгтээс харахад газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэл 2013, 2015, 2017 онуудад тус тус өмнөх жилүүдийнхээсээ буурч, харин тэдгээрээс бусад жилүүдэд өсчээ. Өөрөөр хэлбэл, өсөлт болон бууралт ээлжлэх хандлагатай байна.

Мөн газар тариалангийн салбарын бодлого оновчгүй байснаас үрийн чанар, техник, технологийн үр ашиг, тариаланчдын орлого буурч, өр зээл нэмэгдэж, байгаль, хөрсний доройтол, ургац алдалт зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон бэрхшээл тулгарчээ.

Газар тариалангийн салбарын бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн зорилтуудыг сайн, дунд, тааруу хэрэгжүүлсэн нөхцөлөөс болон өмнөх хугацааны өсөлтийн хандлагаас дараахь төсөөллийг гаргалаа.

#### **Хүснэгт 33. Газар тариалангийн нийт үйлдвэрлэлийн төсөөлөл, оны үнээр (тэрбум төгрөг)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээд хувилбар</b>	739.9	826.2	903	974.4	1042.4	1107.8	1171.3	1233.3
<b>Дунд хувилбар</b>	606.1	646.1	686.2	726.2	766.3	806.3	846.4	886.4
<b>Доод хувилбар</b>	472.3	466	469.3	478	490.1	504.8	521.4	539.5

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

### **2.2.3. Уул уурхайн салбар**

Уул уурхайн салбарын 2018-2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл

Уул уурхайн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг МУТХҮБ-2030, "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого" болон тус салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор томъёолсон 2020-2025 оны салбарын тулгамдсан асуудал зэрэг баримт бичгүүдэд тулгуурлан тодорхойлов. Тухайлбал, 2020-2025 оны тус салбарын дунд хугацааны 6 тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойллоо.

Үүнд:

1. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох;
3. Салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн засаглал, хариуцлага, ил тод байдал, тайлагналтыг сайжруулах;
4. Уул уурхайн түүхий эдийг боловсруулах салбарын хөгжлийг дэмжих;
5. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах;
6. Салбарын бодлого үйл ажиллагааг бусад салбарын бодлого үйл ажиллагаатай уялдуулах;
7. Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах.

МУТХҮБ-2030-д “Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 70 хувийг евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана”, “зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ”, “Жилд 100 мянган тонн ган туйван, барилгын болон төмөр замын металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулна” зэрэг зорилтууд тусгагдсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2018-2020 онд хэрэгжүүлж буй Гурван тулгуурт хөгжлийн бодлого “Оюу толгойн далд уурхайг 2023 оноос ашиглалтад оруулах”, 2020 оноос Таван толгойн нүүрсний ордын дэд бүтцийн төслүүд, түүний дотор “Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн авто ба төмөр зам”, “Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр зам”, “Зүүнбаян-Ханги-Мандал чиглэлийн төмөр зам”, “Таван толгой-Ханги-Мандал чиглэлийн авто болон төмөр зам”, “Таван толгойн 450 Мвт хүчин чадалтай цахилгаан станц”, “Нүүрс угаах, түүнээс нийлэг байгалийн хий гаргах, кокс үйлдвэрлэх” төсөл болон “Алтан ширээд 1,5 сая тн газрын тос боловсруулах”, “Гацууртын алтны ордыг ашиглах”, “Цагаан суваргын зэс молибдений баяжуулах үйлдвэр барих”, “Дархан, Сэлэнгийн хар төмөрлөгийн цогцолбор байгуулах”, “Багануурын үйлдвэр технологийн парк байгуулах”, “Зэсийн баяжмал боловсруулах” зэрэг томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтууд тусгагдсан.

Дээрх төсөл, арга хэмжээнүүд хэрэгжих, ашигт малтмалын төрөл, ордын онцлог, нөөцийн хэмжээ, ашиглалтын нөхцөлд тохирсон тэргүүний техник, технологийг ашиглах, усны нөөцийн зохистой менежмент хэрэглэх зэрэг нөхцлийг тооцон уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн доороос дээш чиглэсэн төсөөллийг хийв. Ингэхдээ, тус салбарын зорилтуудыг хөнгөн ба хүнд аж үйлдвэрлэлийн салбар, эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалтын хөгжлийн зорилтуудтай уялдуулж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг дараах байдлаар тооцоолон төсөөллөө.

**Хүснэгт 34. Уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүний төсөөлөл, 3 хувилбараар**  
(тэрбум төгрөг)

		2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Газрын тос (мян. баррель)</b>	<b>Доод</b>	7932.6	8809.1	9771.7	10574.4	10699	9682.7	6502.7	2448.6
	<b>Дунд</b>	9915.7	11011.3	12214.6	13218	13373.7	12103.3	8128.4	3060.8
	<b>Дээд</b>	12692.2	14094.5	15634.7	16919	17118.4	15492.2	10404.3	3917.8
<b>Зэсийн баяжмал (мян. тн)</b>	<b>Доод</b>	1209.1	1366.1	1555.5	1761.3	1925.8	1849	1594.5	1031.1
	<b>Дунд</b>	1511.4	1707.6	1944.4	2201.6	2407.2	2311.3	1993.2	1288.9
	<b>Дээд</b>	1934.6	2185.8	2488.8	2818.1	3081.2	2958.4	2551.2	1649.7
<b>Молибдений баяжмал (тн)</b>	<b>Доод</b>	4184.4	4232.8	4823.9	5499.4	6219.1	7140.6	7496.3	6293.6
	<b>Дунд</b>	5230.5	5291	6029.9	6874.2	7773.9	8925.7	9370.3	7867
	<b>Дээд</b>	6695	6772.4	7718.3	8799	9950.6	11424.9	11994	10069.8
<b>Төмрийн хүдэр (мян. тн)</b>	<b>Доод</b>	6066.6	6250.1	5851.1	5174	4978.8	7079.1	7949.4	16823.8
	<b>Дунд</b>	7583.2	7812.6	7313.9	6467.5	6223.4	8848.9	9936.7	21029.8
	<b>Дээд</b>	9706.5	10000.1	9361.8	8278.4	7966	11326.5	12719	26918.1
<b>Алт (тн)</b>	<b>Доод</b>	13.8	17.1	20.8	24.4	27.8	30.1	32.5	33.3
	<b>Дунд</b>	17.3	21.4	26.0	30.5	34.8	37.7	40.7	41.7
	<b>Дээд</b>	22.1	27.4	33.3	39	44.5	48.2	52.1	53.3

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрх гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнд үндэслэн уул уурхай, олборлох салбарын 2020-2025 оны нийт үйлдвэрлэлийн төсөөллийг дараах байдлаар хийв.

**Хүснэгт 35. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэлийн төсөөлөл, оны үнээр, 3 хувилбараар**  
(тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дээд хувилбар</b>	6851.4	7169.9	7565.2	7721.6	8199.1	8932.2	9430.8	9925.2
<b>Дунд хувилбар</b>	6337.6	6762.2	7215.2	7698.7	8214.5	8764.8	9352.1	9978.7
<b>Доод хувилбар</b>	6331.6	6749.5	7195	7669.8	8176	8715.7	9290.9	9904.1

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Макро түвшинд дээрээс доош тооцоолсон төсөөллийг тухайн салбарын доороос дээш тооцоолсон төсөөлөлтэй дараах байдлаар харьцууллаа.



**Хүснэгт 36. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр  
(тэрбум төгрөг)**

	<b>2018</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>	<b>2022</b>	<b>2023</b>	<b>2024</b>	<b>2025</b>
<b>Дээрээс төлөвлөсөн төсөөлөл</b>	6851.4	7169.9	7565.2	7721.6	8199.1	8932.2	9430.8	9925.2
<b>Доороос хийсэн тооцоо, дунд</b>	6331.6	6749.5	7194.9	7669.8	8176	8715.6	9290.8	9904.1
<b>Зөрүү</b>	519.8	420.4	370.2	51.8	23.1	216.5	139.9	21.1

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

## БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

### 3.1. Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөлөл

Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн 2018-2025 оны үзүүлэлтүүдийн төсөөллийг хийхдээ ҮСХ-ноос 2017 онд гаргасан “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо” болон МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн ажил эрхлэлт, ажилгүйдлийн хүрэх түвшинг үндэслэн тооцов.

ҮСХ хүн амын тоог дээд, дунд, доод гэсэн 3 хувилбараар тооцсон бөгөөд түүнд 2017 оны хүн амын тооны гүйцэтгэлээр засвар оруулан цаашдын өсөлт, өөрчлөлтийн чиг хандлагыг нь хэвээр хадгалсан 3 хувилбартай нэмэлт тооцоог хийсэн. Тооцооны үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

#### Хүснэгт 37. Хүн амын тооны төсөөлөл, жилийн эцэст (мянган хүн, тоо)

	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
ҮСХ-ны Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцооны дунд хувилбар (гадаадад оршин суугч Монголчууд ороогүй)	3089.6	3153.2	3216.7	3279.4	3341.6	3403.1	3463.6	3522.6	3581.6
Жил бүрийн цэвэр өсөлтийн хувь		2.06	2.01	1.95	1.9	1.84	1.78	1.71	1.66
2017 оны гүйцэтгэлээр засварласан суурин хүн амын доод хувилбар	3177.9	3225.6	3290.31	3354.47	3418.2	3481.1	3543.06	3603.65	3663.47
2017 оны гүйцэтгэлээр засварласан суурин хүн амын дундаж хувилбар	3177.9	3243.4	3308.6	3373.1	3437.2	3500.4	3562.7	3623.6	3683.8
2017 оны гүйцэтгэлээр засварласан суурин хүн амын дээд хувилбар	3177.9	3260.5	3326.1	3390.9	3455.4	3518.9	3581.6	3642.8	3703.3
Жилийн дундаж хүн амын тоо		3210.6	3276	3340.8	3405.1	3468.8	3531.6	3593.2	3653.7
Тооцооны зөрүү		90.2	91.9	93.7	95.6	97.3	99.1	100.7	102.5
Зөрүүний завсарласан хүн амд эзлэх хувь		2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Тайлбар: ҮСХ-ны 2018-2025 оны хүн амын хэтийн тооцоог засварлахдаа 2017 оны хүн амын тооны жинхэнэ гүйцэтгэлд суурилан дээр тооцсон жил бүрийн цэвэр өсөлтийн хувийг хэвээр хадгалан шинэчлэн тооцов. Хэтийн тооцоогоо 2017 оны эцсийн хүн ам 3089,6 мянга ба 31177,9 мянга гарсан тул гүйцэтгэлээр нь авсан.

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15 ба түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Иймээс, бид 15 ба түүнээс дээш насны хүн амыг ҮСХ-ны хэтийн тооцооноос түүвэрлэн авч, зохих засвар оруулан хөдөлмөрийн насны хүн амын 2018-2025 оны тоог тодорхойлсон. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог ажиллах хүчний оролцооны түвшинг ашиглан 15 болон түүнээс дээш насны хүн амын тооноос шууд тооцов. Ажилгүй иргэдийн тоог ажилгүйдлийн түвшинг ашиглан эдийн засгийн идэвхтэй хүн амын тооноос тооцон

тогтоов. Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн ам болон ажилгүй иргэдийн тооны зөрүүгээр тооцсон.

**Хүснэгт 38. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөлөл, доод хувилбар**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>2017 оны гүйцэтгэлээр засварласан суурин хүн ам</b>	3225.5	3290.3	3354.5	3418.2	3481.1	3543.1	3603.7	3663.5
<b>Тооцоог засварласан 15 ба түүнээс дээш насны хүн ам, доод хувилбар, (мянга)</b>	2295.3	2322	2351.1	2420.4	2438.3	2456.5	2496.9	2539.6
<b>Эдийн засгийн идэвхтэй хүн ам, (мянга)</b>	1409.3	1430.4	1453	1500.6	1521.5	1537.7	1568.1	1599.9
<b>Ажиллагчид, мянга</b>	1288.1	1308.8	1330.9	1376.1	1396.7	1413.2	1442.6	1471.9
<b>Ажилгүй иргэд, (мянга)</b>	121.2	121.6	122	124.6	124.8	124.6	125.4	128
<b>Ажиллах хүчний оролцооны түвшин</b>	61.4	61.6	61.8	62	62.4	62.6	62.8	63
<b>Хөдөлмөр эрхлэлтийн түвшин</b>	56.1	56.4	56.6	56.9	57.3	57.5	57.8	58
<b>Ажилгүйдлийн түвшин</b>	8.6	8.5	8.4	8.3	8.2	8.1	8.0	8

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

МУТХҮБ-2030-ын хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдлын талаар дэвшүүлсэн бодлогын Зорилт 2-ын II үе шатанд (2021-2025) “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх” гэж тодорхойлсон. Доод хувилбарт бид дээрх зорилтыг хамгийн муу хэрэгжилттэй байхаар буюу 63 болон 8 хувиар авсан бөгөөд энэхүү түвшинг 2018-2024 онуудад жигд хуваарилан тооцсон. Энэ хэсгийг ялган будав.

**Хүснэгт 39. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны төсөөлөл, дунд хувилбар**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Монгол Улсад оршин сууж байгаа хүн амын тоо, оны эцэст (мянга)</b>	3243.4	3308.6	3373.1	3437.2	3500.4	3562.7	3623.6	3683.8
<b>ҮСХ-ны хэтийн тооцооны 15 ба түүнээс дээш насны хүн ам (мянга)</b>	2245.2	2271.3	2299.7	2367.5	2385.0	2402.8	2442.4	2484.1
<b>Тооцоог засварласан ба 15 ба түүнээс дээш насны хүн ам (мянга)</b>	2308.1	2334.9	2364.1	2433.8	2451.8	2470.1	2510.8	2553.7

Нийт хүн амд 15 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	71.2	70.6	70.1	70.8	70	69.3	69.3	69.3
Эдийн засгийн идэвхтэй хүн ам (мянга)	1419.5	1447.6	1477.6	1533.3	1556.9	1580.9	1619.5	1659.9
Ажиллагчид, (мянга)	1305.9	1336.2	1366.7	1421.4	1447.9	1474.9	1517.4	1560.3
Ажилгүй иргэд (мянга)	113.6	111.5	110.8	111.9	109	105.9	102	99.6
Ажиллах хүчний оролцооны түвшин	61.5	62	62.5	63	63.5	64	64.5	65
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	56.6	57.2	57.8	58.4	59.1	59.7	60.4	61.1
Ажилгүйдлийн түвшин	8	7.7	7.5	7.3	7	6.7	6.3	6

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дунд хувилбарт бид хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 65 хувь, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүрнэ гэж төсөөлөв.

**Хүснэгт 40. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийн 2018-2025 оны прогноз (дээд хувилбар)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
2017 оны гүйцэтгэлээр засварласан суурин хүн амын дээд хувилбар	3260.5	3326.1	3390.9	3455.4	3518.9	3581.6	3642.8	3703.3
Тооцоог засварласан 15 ба түүнээс дээш насны хүн ам, дээд хувилбар, (мянга)	2320.3	2347.1	2376.6	2446.7	2464.8	2483.2	2524.1	2567.2
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, (мянга)	1427	1455.1	1497.3	1565.9	1602.1	1638.9	1691.1	1745.7
Ажиллагчид, (мянга)	1312.8	1353.4	1407.4	1476.6	1514	1556.9	1615	1675.9
Ажилгүй иргэд, (мянга)	114.2	101.9	89.8	89.3	88.1	81.9	76.1	69.8
Ажиллах хүчний оролцооны түвшин	61.5	62	63	64	65	66.0	67	68
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	56.6	57.7	59.2	60.4	61.4	62.7	64	65.3
Ажилгүйдлийн түвшин	8	7	6	5.7	5.5	5	4.5	4

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээд хувилбарт бид МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилтын дагуу хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувь, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүрнэ гэж үзсэн. Хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвх болон ажилгүйдлийн түвшингийн талаар МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилтыг яагаад зөвхөн дээд хувилбараар авсан бэ гэдэг асуулт зүй ёсоор гарна. Нөхцөл байдлын шинжилгээнээс болон өмнөх онуудын гүйцэтгэлээс үзэхэд хөдөлмөрийн насны хүн


амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх зорилт нь өндөр бөгөөд их хүчин чармайлт гаргаж байж хэрэгжих магадлалтай зорилт тул дээд хувилбарт сонгон авсан.

### **3.2. Ядуурлыг бууруулах зорилтын төсөөлөл**

МУТХҮБ-2030-д 2025 гэхэд ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтыг хангахын тулд 2025 он хүртэлх хугацаанд ядуурлыг ямар үе шаттай бууруулсан байх шаардлагатайг доорх зурагт харуулав.

#### **Зураг 25. Ядуурлыг 2018-2025 онд бууруулах төсөөлөл**

(хувь)




Эх сурвалж: ҮХГ-ын судалгааны багийн тооцоо.

МУТХҮБ-2030-д ядуурлын хамралтын түвшинг 2020 онд 18 хувьд хүргэж бууруулах зорилт тавьсаныг энэхүү төсөөлөлд шууд авсан. Уг төсөөлөл нь ДНБ-ий тооцоо болон бусад үзүүлэлттэй холбоогүй бөгөөд зөвхөн МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилтыг завсрын онуудад хуваарилсан тооцоо болно.

### **3.3. Хүний хөгжил**

МУТХҮБ-2030-д хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно гэсэн зорилтыг 2030 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн.

**Зураг 26. Хүний хөгжлийн индекс, улс орнуудын бүлгээр, 2017 он**



Эх сурвалж: НҮБ, Хүний хөгжлийн индексийн тоон өгөгдлийн сан, 2018.

Монгол Улс 2015 оны байдлаар хүний хөгжил дундаж орнуудын бүлгээс гарч, хүний хөгжил өндөр орнуудын бүлэгт багтаж эхэлсэн байна. Манай орны Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2017 оны байдлаар 0,741 болж, дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлтээр 92 дүгээр байранд жагсжээ.


**Хүснэгт 41. Монгол Улсын хүний хөгжлийн индекс**

	2005	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
<b>ХХИ</b>	0.649	0.697	0.706	0.72	0.722	0.734	0.737	0.743	0.741

Эх сурвалж: НҮБ, Хүний хөгжлийн индекс тоон өгөгдлийн сан, 2018.


Монгол хүний хөгжлийн индекс тасралтгүй өссөөр ирснийг доорх зургаас харж болно.

**Зураг 27. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс**



ХХИ-ийн 2018-2025 оны төсөөллийг доорх байдлаар дүрслэв.

### Зураг 28. Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн 2018-2025 оны таамаглал



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.


МУТХҮБ-2030-д хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болохыг үнэлж дүгнэхэд хүндрэлтэй байна.

### 3.4. Боловсролын салбарын зарим үзүүлэлтийн 2018-2025 оны төсөөлөл

Монгол Улсын 2018-2025 оны боловсролын салбарын хөгжлийн зарим үзүүлэлтүүдийн төсөөллийг хийхдээ сүүлийн 10 жилийн (2008-2017 оны) хөгжил, өөрчлөлтийн чиг хандлагыг тооцож, дунд хугацааны төсөөлөлдөө гол үндэслэл болгов. Үүний зэрэгцээ МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн бодлогын зорилтууд болон үндсэн үзүүлэлтүүдийн 2025 онд хүргэхээр дэвшүүлсэн зорилтот түвшинг харгалзан үзсэн.

Боловсролын салбарын өмнө тулгамдаад байгаа боловсролын чанарын асуудалд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, хамрагдалт ихээхэн нөлөөтэй.

### Зураг 29. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд (хувь)



Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2005-2017, [www.1212.mn](http://www.1212.mn).

Хүснэгтээс харахад сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 2001 оноос хойш тасралтгүй өссөн байна.

МУТХҮБ-2030-ын “Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ” гэсэн зорилтыг сайн, дунд, тааруу хэрэгжүүлсэн нөхцлөөр болон өмнөх хугацааны хандлагаас дараах төсөөллийг гаргалаа.

**Хүснэгт 42. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тооны төсөөлөл**  
(хувь)

	2018	2019	2020	2021	2022	2023
<b>Дунд хувилбар</b>	86	89.1	92.2	95.3	98.4	100
<b>Доод хувилбар</b>	85.4	88.5	91.6	94.7	97.8	100
<b>Дээд хувилбар</b>	86.6	89.7	92.8	95.9	99.1	100

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

МУТХҮБ-2030-ын боловсролын салбарын нэг зорилт нь 2025 он гэхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 80 хувийг хамруулах явдал юм. Гэвч энэ зорилт 2017 онд хангагдсан бөгөөд өмнөх хугацааны хандлагыг харахад 2025 он хүртэл уг хувь өсөх бөгөөд 2023 оноос энэхүү зорилт 100 хувь биелэгдэхээр байна.

**Хүснэгт 43. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо**  
(хүүхдийн тоо)

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Цэцэрлэгийн хүүхдийн тоо (мянган хүүхэд)</b>	122.1	133.4	150.2	167.9	206.6	225.4	243.4	256.7
<b>Үндсэн багшийн тоо</b>	5025	4907	5332	5894	6158	6833	7302	7745
<b>Нэг багшид ноогдох хүүхдийн тоо</b>	24	27	28	29	34	33	33	33

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2017, [www.1212.mn](http://www.1212.mn).

Хүснэгтээс харахад 2010 оноос үндсэн багшийн тоо өссөн боловч сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо илүү хурдан нэмэгдсэн тул нэг багшид ногдох хүүхдийн тоо нэмэгджээ. Иймд, төрийн зүгээс сургуулийн өмнөх боловсролын багш нарын тоог нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

**Хүснэгт 44. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тооны төсөөлөл**  
(хүүхдийн тоо)

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Дунд хувилбар</b>	36	37	39	40	41	43	44	45
<b>Доод хувилбар</b>	34	35	37	38	39	41	42	43
<b>Дээд хувилбар</b>	38	39	41	42	43	45	46	48

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

МУТХҮБ-2030-д цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоог 2025 онд 25 болгон бууруулахаар заасан. Гэвч өмнөх хугацааны хандлагыг харахад тус үзүүлэлт 2025



онд зорилтод түвшингээсээ бараг 2 дахин их байх шинжтэй байна. Иймд, цэцэрлэгийн багш нарын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Доорх хүснэгтэд МУТХҮБ-2030-ын 2025 оны зорилтот утга болон түүнд хүрэх төсөөллийг дунджийн аргаар тооцооллоо. Хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 2025 онд 30, 2030 онд 50 болгоно гэсэн зорилт дэвшүүлсэн.

**Хүснэгт 45. Хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулах хувь**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Үзүүлэлт	4	8	12	16	18	22	26	30

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Анги дүүргэлтийн улсын дундаж үзүүлэлтийг төсөөлөхөд нэг ангид суралцагч хүүхдийн дундаж тоо буурах хандлагатай байна.

**Хүснэгт 46. Анги дүүргэлтийн улсын дундаж үзүүлэлтийн төсөөлөл**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Үзүүлэлт	32	31	30	29	28	27	26	25

Эх сурвалж: ҮХГ-ын судалгааны багийн тооцоо.

Их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тооноос илүү чанарт анхаарч, мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэжилтнийг бэлтгэхэд илүү анхаарах хэрэгтэй байгааг салбар бүрийн хэлэлцүүлгийн явцад ажил олгогчид онцолж байв.

**3.5. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтийн 2018-2025 оны төсөөлөл**

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийн зарим үзүүлэлтийн 2018-2025 оны төсөөллийг хийхдээ сүүлийн 10 жилийн (2008-2017) оны хөгжил, өөрчлөлтийн чиг хандлагыг судалж, дунд хугацааны төсөөлөлдөө гол үндэслэл болгов. Үүний зэрэгцээ МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн бодлогын зорилтууд болон үндсэн үзүүлэлтүүдийн 2025 онд хүргэхээр дэвшүүлсэн зорилтот түвшинг харгалзан үзсэн.

**3.5.1. Дундаж наслалт**

Эрүүл мэндийн салбарын хүрээнд МУТХҮБ-2030-ын 2025 онд хүрэх нэг зорилт нь хүн амын дундаж наслалтыг уртасгаж, 74-д хүргэх зорилт юм.

**Хүснэгт 47. Хүн амын дундаж наслалтын өмнөх онуудын түвшин (жил)**

Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Дундаж наслалт	63.51	63.63	64.58	65.21	65.85	66.54	67.23	67.96

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Дундаж наслалт	68.05	68.32	68.71	69.11	69.57	69.89	69.57	69.89

Өмнөх онуудын хүрсэн түвшингээс харахад хүн амын дундаж наслалт улсын хэмжээнд ерөнхийдөө өсөх хандлагатай байна.

**Хүснэгт 48. Хүн амын дундаж наслалтын 2018-2025 оны төсөөлөл**  
(жил)

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	71.29	71.75	72.2	72.65	73.1	73.56	74.01	74.46
Доод хувилбар	70.28	70.74	71.19	71.64	72.09	72.54	73	73.45
Дээд хувилбар	72.3	72.76	73.21	73.66	74.11	74.57	75.02	75.47


Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дунд хувилбараас харахад 2025 оны зорилтот түвшинд хүрэхэд бодлогын дэмжлэг гарцаагүй шаардагдаж байна. Иймд нялхсын нас баралтыг бууруулах, ялангуяа эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс даруй 9 жилээр доогуур байгааг анхаарч, тэдний хувьд урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, оношилгоо, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг эрчимтэй явуулах хэрэгтэй.

**3.5.2. Эхийн эндэгдэл**

МУТХҮБ-2030-д 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 2025 онд 20 болгох зорилт дэвшүүлсэн.

**Зураг 30. 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин**



Өмнөх онуудын хүрсэн түвшингээс харахад 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин улсын хэмжээнд ерөнхийдөө буурах хандлагатай байна.

**Хүснэгт 49. 100 мянган амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн төсөөлөл**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	28	26	24	23	21	19	17	15

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Хүснэгтээс харахад 2025 оны зорилтот түвшинд хүрэх бүрэн бололцоотой байна.

**3.5.3. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл**

МУТХҮБ-2030-д 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 2025 онд 12 болгох зорилт дэвшүүлсэн.

**Хүснэгт 50. 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин**

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Улсын дүн	23.2	21.7	23.2	23.5	25.6	20.2	18.9	18	18.2	18

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2016.

Хүснэгтээс харахад 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин улсын хэмжээнд ерөнхийдөө буурах хандлагатай байна.

**Хүснэгт 51. 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн төсөөлөл, 3 хувилбараар**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	15.5	14.8	14.1	13.4	12.7	12	11.3	10.6
Дээд хувилбар	11.8	11.1	10.3	9.6	8.9	8.2	7.4	6.7
Доод хувилбар	19.2	18.5	17.9	17.2	16.5	15.8	15.2	14.5


Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Тооцооллоос харахад 2025 оны зорилтот түвшинд хүрэх бүрэн бололцоотой.

**3.5.4. Нялхсын эндэгдэл**

МУТХҮБ-2030-д 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшинг 2025 онд 11 болгох зорилт дэвшүүлсэн.

**Зураг 31. Нялхсын эндэгдлийн түвшин**



Хүснэгтээс харахад нялхсын эндэгдлийн түвшин улсын хэмжээнд ерөнхийдөө буурах хандлагатай байна.

**Хүснэгт 52. Нялхсын эндэгдлийн тооны төсөөлөл, 3 хувилбараар**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	13.1	12.5	11.9	11.2	10.6	9.9	9.3	8.7
Доод хувилбар	12.1	11.5	10.8	10.2	9.6	8.9	8.3	7.7
Дээд хувилбар	14.1	13.5	12.9	12.2	11.6	11	10.3	9.7


Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Таамаглалаас харахад 2025 оны зорилтот түвшинд хүрэх бүрэн бололцоотой байна.

**3.5.5. Зарим төрлийн өвчнөөс шалтгаалсан нас баралтын талаарх төсөөлөл**

МУТХҮБ-2030-д 10 мянган хүн амд ногдох зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралтын тоог 2025 онд 16 болгох зорилт дэвшүүлсэн.

**Зураг 32. Зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралт (хувь)**



Зургаас харахад зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралтын тоо улсын хэмжээнд ерөнхийдөө буурах хандлагатай байна.

**Хүснэгт 53. Зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралтын тооны төсөөлөл (хувь)**


Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	16.6	16	15.4	14.8	14.2	13.6	13	12.4
Доод хувилбар	15.6	15	14.4	13.8	13.2	12.6	12	11.3
Дээд хувилбар	17.6	17	16.4	15.8	15.2	14.6	14	13.4

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Төсөөллөөс харахад 2025 оны зорилтот түвшинд хүрэх бүрэн бололцоотой.

МУТХҮБ-2030-д 10 мянган хүн амд ногдох хавдраас шалтгаалсан нас баралтын тоог 2025 онд 9 болгох зорилт дэвшүүлсэн.

**Зураг 33. 100 мянган хүн амд ногдох хавдраас шалтгаалсан нас баралт (хувь)**



Хүснэгтээс харахад хавдрын өвчнөөс шалтгаалсан нас баралтын тоо улсын хэмжээнд ерөнхийдөө өсөх хандлагатай байна.

**Хүснэгт 54. Хавдраас шалтгаалсан нас баралтын тооны төсөөлөл, 3 хувилбараар (Хувь)**

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дунд хувилбар	12.9	13	13	13.1	13.1	13.2	13.2	13.3
Доод хувилбар	11.9	11.7	11.6	11.5	11.3	11.3	11.2	11.1
Дээд хувилбар	13.9	14.2	14.5	14.7	14.9	15.1	15.3	15.5

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Хавдраас шалтгаалсан нас баралтын тоо өсөх хандлагатай байгаа нь 2025 оны зорилтот түвшинд хүрэхэд хүндрэлтэйг харуулж байна. Иймд хавдрын эрт оношлолт, хавдрын эмчилгээг сайжруулах бодлогыг цаашид илүү оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай.

## БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2018-2025 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

МУТХҮБ-2030-д байгаль орчны 3 бүлэг асуудлаар урт хугацааны зорилт дэвшүүлэн тавьсан. Эдгээр зорилтыг хангах хүрээнд байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал нөлөөтэй дараах үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх замаар 2025 он хүртэлх байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээг тодорхойллоо.

### 4.1. Ногоон хөгжил

МУТХҮБ-2030-ын эдийн засгийн хүрээний зорилтод ногоон эдийн засгийн үзүүлэлтээр 2030 онд дэлхийд 30 дугаар байр эзлэх зорилт тусгагдсан юм. 2018 оны байдлаар Дэлхийн ногоон эдийн засгийн индексд Монгол Улс 130 орноос 120 дугаар байранд байна. 2016 онд 80 орноос 79 дүгээр байранд орж байсан. 2016 оны индекс нь 35,01 байсан бол 2018 онд 38,3 болж нэмэгджээ. Хэдийгээр ногоон эдийн засгийн индекс өсөлттэй харагдаж байгаа боловч зорилтот түвшинд хүрэх боломж хомс байна. Энэхүү зорилтын үзүүлэлтийг эзлэх байраар биш харин индексийн үзүүлэлтээр хэмжих нь илүү нийцтэй юм. Орчин үед хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа томоохон сорилт бол дэлхийн дулаарал юм. Дэлхийн дулаарал цаашид нэмэгдээд байвал экологийн тэнцвэрт байдал алдагдаж сүйрэлд хүргэх аюултай болохыг эрдэмтэн судлаачид анхааруулсаар байна. Дэлхийн дулаарлыг нэмэгдүүлж байгаа гол хүчин зүйл бол хүлэмжийн хийн ялгаруулалт юм.

Иймээс хүлэмжийн хийг бууруулах тэмцэлд улс орнууд нэгдэж, 2015 онд Францын нийслэл Парис хотноо дэлхийн 196 орны төр засгийн удирдагчид цуглан цаашид авах арга хэмжээний тунхаглалыг баталсан билээ.


### 4.2. Хүлэмжийн хийн ялгарал

Дараах хүснэгтүүдэд манай орны хүлэмжийн хийн шингээлт, ялгаруулалтын биет болон цэвэр өсөлтийн сүүлийн жилүүдийн мэдээллийг харуулав.

#### Хүснэгт 55. Нийт хүлэмжийн хийн шингээлт, ялгарал, (мянган тонн CO<sub>2</sub>-эке)

Он	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
CO <sub>2</sub>	-5814.6	-1885.5	150.9	935.05	1710.5	-447.9	2288.6	5728	8139.6	10030.8

**Зураг 34. Хүлэмжийн хийн ялгаралтын цэвэр өсөлт, бууралт (хувь)**



Зургаас харахад нийт хүлэмжийн хийн шингээлт, ялгарал улсын хэмжээнд ерөнхийдөө өсөх хандлагатай байна. МУТХҮБ-2030-д байгаль орчны салбарын нэг чухал зорилт болсон хүлэмжийн хийн ялгарлыг 2025 гэхэд 7 хувиар бууруулахаар заасан юм.

Манай орны өмнөх жилүүдийн хүлэмжийн хийн үзүүлэлтүүдийн утгаас хамааруулан 2025 он хүртэл гаргасан таамаглалыг 3 хувилбараар хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 56. Хүлэмжийн хийн ялгарал (мянган тонн CO<sub>2</sub>-экв)**

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
<b>Доод хувилбар</b>	-761.67	-771.14	-780.6	-790.07	-799.55	-809.03	-818.52	-828.01
<b>Дунд хувилбар</b>	-182.69	-192.14	-201.	-211.05	-220.5	-229.95	-239.4	-248.85
<b>Дээд хувилбар</b>	396.29	386.85	377.42	367.98	358.55	349.13	339.71	330.3

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Таамаглалын тооцоолол болон өмнөх жилүүдийн байдлаас үзэхэд хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ өсөх хандлагатай байгаа нь зорилтот түвшинд хүрэхэд хүндрэлтэй гэдгийг нотолж байна.


Иймээс, хүлэмжийн хийн хэмжээг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлсэн бодлого, арга хэмжээ зайлшгүй хэрэгтэй. Хүлэмжийн хийн ялгаруулалтад нөлөөлж буй хүчин зүйлст нүүрсээр галладаг дулааны цахилгаан станцууд, дотоод шаталтын хөдөлгүүртэй олон мянган авто машин, техник болон их хэмжээний газар нутгийг хамарсан ой, хээрийн түймэр, хүн, мал амьтны тоо толгойн өсөлт, ногоон бүрхэвчийн доройтол зэрэг нүүрс хүчлийн давхар ислийг үүсгэж байгаа бүхэн багтаж байна.

Иймд, хүлэмжийн хийг бууруулахын тулд сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй ашиглах, цахилгаан авто машины үйлдвэрлэл, байгальд халгүй дэвшилтэт техник технологийн хөгжлийг хангах, үйлдвэрлэлд хаягдалгүй технологи ашиглах, малын тоо толгойг зохистой түвшинд хадгалах, ой хээрийн түймрийн дэгдэлтийг зогсоох, гол усны эх бүрэлдэх хэсгийг хамгаалах, хот суурины ногоон байгууламж, ой, ургамлын эзлэх талбайг нэмэгдүүлэх талаар төр, хувийн хэвшил, байгууллага, иргэн бүр хувь нэмрээ оруулах шаардлагатай.

### 4.3. Ойгоор бүрхэгдсэн талбай

МУТХҮБ-2030-д тусгагдсан байгаль орчны салбарын нэг зорилт нь нийт газар нутгийн ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувийг 2025 онд 8,7 хувьд хүргэх явдал юм.

**Зураг 35. Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн газар**  
(эзлэх хувь)



Манай орны ойгоор бүрхэгдсэн газар нутгийн талбайн үзүүлэлтүүдийн хандлагаас хамааруулан 2025 он хүртэлх төсөөллийг 3 хувилбараар тооцон хүснэгтэд үзүүлэв.

Доорх тооцооллыг хийхдээ ой модоор бүрхэгдсэн газар ба мод үржүүлгийн газрын талбайн нийлбэрийг нийт Монгол Улсын газрын нэгдмэл сангийн дүнд хувааж 100-аар үржүүлж хувиар илэрхийлсэн болно.

**Хүснэгт 57. Ойгоор бүрхэгдсэн газар нутгийн талбайн, 3 хувилбараар**  
(эзлэх хувь)

	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Доод хувилбар	7.76	7.71	7.67	7.62	7.58	7.53	7.47	7.42
Дунд хувилбар	7.84	7.85	7.86	7.87	7.88	7.89	7.9	7.91
Дээд хувилбар	7.93	7.99	8.05	8.12	8.18	8.25	8.32	8.39

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Энэхүү хүснэгтээс харахад ойгоор бүрхэгдсэн газар нутгийн талбайг нийт газар нутгийн хэмжээнд харьцуулсан харьцаа маш алгуур боловч өсч байгаа хандлага ажиглагдаж байна. Энэ нь манай улс ойн нөөцөө дорвитой нэмэгдүүлж, ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Цөлжилтийг бууруулах, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэхэд ус чийгний эх булаг болсон ойн нөөцийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөгшин ойг цэвэрлэх, түймэрт идэгдсэн олон зуун мянган га газрын ойн модыг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатай байна.

Хот суурины ногоон байгууламжийг нэмэгдүүлэхдээ зэрлэг ойгоос мод зөөдгийг зогсоож, мод үржүүлгийн аж ахуйгаас суулгац тарьдаг зарчимд шилжих шаардлагатай юм.



Тооцоолсон төсөөллөөс харахад 2025 онд ойгоор бүрхэгдсэн газар нутгийн хэмжээг нийт нутгийн 8,7 хувьд хүргэх зорилтыг хангах боломж муутай байна. Энэхүү зорилтыг хангахын тулд жил бүр ойгоор бүрхэгдсэн газрын хэмжээг 0,1 хувиар тогтмол нэмэгдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.

#### **4.4. Байгаль орчны бусад үзүүлэлтүүд**

МУТХҮБ-2030-д тусгагдсан байгаль орчны салбарын нэг том зорилт нь улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг 2030 онд 30 хувьд хүргэх явдал юм. Дараах хүснэгтүүдэд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг биет болон эзлэх хувиар харуулав.

#### **Хүснэгт 58. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ**

(мянган га)

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Газар нутгийн хэмжээ	20943.9	20948.3	20948.3	21140.9	21140.9	21144.7	21140.9

**Эх сурвалж:** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар.

#### **Хүснэгт 59. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ**

(хувь)

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Эзлэх хувь	13.4	13.4	13.4	13.5	13.5	13.5	13.5

**Эх сурвалж:** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар.

Дээрх хүснэгтүүдээс харахад 2017 оны байдлаар манай улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ нийт нутгийн 13,5 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд улсын тусгай хамгаалалтад авагдсан газар нутгийн хэмжээ тогтмол түвшинд хадгалагдаж байна.

Дараах хүснэгтэд тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээний өмнөх жилүүдийн хандлагад тулгуурлан тооцсон төсөөллийг үзүүлэв.

#### **Хүснэгт 60. Улсын тусгай хамгаалалтанд авах газар нутгийн хэмжээний 2025 он хүртэлх төсөөлөл**

(хувь)

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Эзлэх хувь	13.53	13.54	13.56	13.57	13.59	13.6	13.61	13.63

*Эх сурвалж:* ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Өмнөх жилүүдийн хандлагад тулгуурлан тооцсон төсөөллөөс харахад 2030 онд тавьсан зорилтод хүрэх боломжгүй байна. Харин тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг жил бүр 1,3 хувиас багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх замаар 2030 оны зорилтыг хангах боломжтой юм.

МУТХҮБ-2030-д хүрэх түвшин нь тусгагдсан байгаль орчны салбарын холбогдолтой дараах зорилтуудыг 2025 он хүртэл жил бүр жигд хэрэгжүүлэхээр таамаглалыг дэвшүүлж дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 61. Байгаль орчны зарим үзүүлэлтийн 2025 он хүртэлх төсөөлөл**  
(хувь)

	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх газар нутгийн эзлэх хувь	13	15	17	19	21	22	23
Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувь	13	15	17	19	21	23	25
Нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	18	20	22	24	26	28	30
Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь	79	80	81	82	83	84	85
Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь	38	40	42	44	46	48	50
Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн тусгай хамгаалалтад авах хувь	49	50	51	52	53	54	55
Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ, хувь	75.2	74.6	74	73.4	72.8	72.2	71.6

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрх үзүүлэлтүүдийг 2025 оны зорилтот түвшинд хүргэхийн тулд өмнөх жилүүдийн өгөгдлийг жил бүр тогтмол өсгөх замаар тооцоолол хийлээ.

Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх газар нутгийн эзлэх хувийг өнөөгийн түвшнөөс 10 хувь, хот суурины ногоон байгууламжийг 12 хувиар, нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг 12 хувиар, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог 6 хувиар, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн тоог 12 хувиар, усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлж, цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээг 6,3 хувиар бууруулах замаар 2025 оны зорилтот түвшинд хүргэхээр тооцоолов.



## САНАЛ, ДҮГНЭЛТ

### 1. Ерөнхий дүгнэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалах чиглэлээр бидний хийсэн 2018-2025 оны төсөөлөл нь өмнөх он жилүүдийн бодит гүйцэтгэл болон МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилтот түвшинд тулгуурласныг тэмдэглэсэн. Ирэх он жилүүдийн нөхцөл байдал тодорхойгүй, олон хүчин зүйлийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй байгаа учраас ихэнх үзүүлэлтийг 3 хувилбараар харуулав.

Бидний дээрх төсөөллүүд бодит амьдралд хэрэгжих эсэх нь олон хүчин зүйлээс хамаарна. Хамгийн таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд, тухайлбал, манай экспортын гол бүтээгдэхүүн нүүрс, зэс, алтны үнэ дэлхийн зах зээл дээр 2019 оноос бага зэрэг буурах боловч боловсруулах аж үйлдвэрийн зарим салбарууд сэргэж, томоохон төслүүд хэрэгжиж, 2023 оноос газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсон нөхцөлд эдийн засгийн өсөлт дээд хувилбараар жил тутам 7 хувиар өсөх боломжтой гэж үзсэн. Дээд хувилбараар 2019 онд нүүрсний экспорт 2018 оныхоос нэмэгдэнэ гэж төсөөлсөн тул 2019 онд эдийн засгийн өсөлт дээд хувилбараар 8 хувьд хүрнэ гэж үзэв. Сангийн яам ч мөн ийм таамаглал дэвшүүлсэн.

Төрийн бодлого тогтвортой байж, Засгийн газар дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээгээ бодитой хэрэгжүүлсэн нөхцөлд дунд хугацааны хөгжлийн таамагласан түвшинд хүрч, дэвшүүлсэн зорилт хэрэгжих үндэслэлтэй гэж үзэж байна. Нөгөө талаар, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн өнөөгийн тогтолцоогоо хөгжүүлж, бидний хийсэн таамаглал төсөөллийг салбарын бүх яам, агентлагууд, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор үндэсний хэмжээний иж бүрэн төлөвлөгөө болгон нарийвчлан тодорхойлж, эрх бүхий байгууллагаас албан ёсоор батлан, түүнийг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай.

Өмнөх жилүүдийн байдлаас харахад шинэ Засгийн газар гарч ирээд өмнөх Засгийн газрын дэвшүүлсэн зорилт, эхлүүлсэн ажлыг гүйцсэн зогсоож, шинэ зорилт, ажлыг эхэлдэг харамсалтай гашуун сургамж үлдсэн. Төр засгийн үйл ажиллагаа ийм арга барилаар цаашид үргэлжилбэл бидний төсөөлөл хэрэгжихгүй үлдэх магадлалтай. Олон Засгийн газрын үед байнга яригддаг боловч ажил хэрэг болоогүй төслүүд, бүтээн байгуулалтын ажлууд байгаа билээ. Ирээдүйд Монгол Улсын эдийн засагт нөлөө бүхий олон бүтээн байгуулалт бодитой хэрэгжих эсэх нь баталгаагүй байна. V цахилгаан станцыг барьж байгуулах асуудал үүний тод жишээ юм. Таван толгойн нүүрсний ордыг түшиглээд цахилгаан станц байгуулах асуудал бидний төсөөлөлд бас хамааралтай.

Хөгжлийн төлөвлөлтийг сайн хийж, түүнийгээ бодитой хэрэгжүүлж ирсэн улс орнуудын туршлагаас харахад тухайн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд хүчирхэг хувийн хэвшил шийдвэрлэх үүрэгтэй гэдэг нь тодорхой юм. Иймээс төр, засгаас хувийн хэвшилээ бодитой дэмжих талаар уламжлалт бус, цоо шинэлэг байдлаар хандах шаардлага гарч байна.

Нөгөө талаас, гадаад орчны нөхцөл бидний төсөөллийн хэрэгжилтэд хүчтэй нөлөө үзүүлэх болно. Дэлхийн болон бүс нутгийн эдийн засаг, санхүүгийн орчин хэр зэрэг таатай байх, мөн манай экспортын түүхий эдийг хүлээн авдаг БНХАУ-ын талаас явуулах бодлого, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ ямар байх зэрэг нь манай эдийн засаг, нийгмийн хөгжилд урьдын адил нөлөөлөх болно.

2018-2025 онд эдийн засгийн өндөр өсөлтийг хангах гол урьдчилсан нөхцөл

бол МУТХҮБ-2030-д заасны дагуу манай оронд хөгжих боломжтой боловсруулах аж үйлдвэрийн салбаруудыг сэргээн хөгжүүлэх, эхний ээлжинд хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хөнгөн, хүнсний үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд түлхүү анхаарах явдал юм. Үүний зэрэгцээгээр хүнд аж үйлдвэрийн, тухайлбал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай. Эрдэнэт, Оюутолгой, Цагаан суваргын олборлох үйлдвэрүүдийг түшиглэн зэс боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх нь зүйтэй.

Хүнд аж үйлдвэрийн нэр бүхий үйлдвэрүүдийг байгуулахад эрчим хүчний шинэ эрэлт үүсэх учраас хүрэн нүүрсний томоохон ордуудаа түшиглэн цахилгаан станцууд барих, одоогоор цахилгаан эрчим хүчнийхээ 20 хувийг импортоор авч байгааг зогсоож, цаашдаа цахилгаан эрчим хүчийг экспортлох бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Дэлхийн дулаарлын асуудлаар тохиролцсон Парисын гэрээний дагуу нүүрсний хэрэглээг дэлхий даяар бууруулахад анхаарч байгаа учраас тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж муу болох тул дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх бүхий л боломжийг ашиглахад анхаарах шаардлагатай байна. Санхүүжилтийн тодорхой арга замыг доорх байдлаар санал болгов.

## **2. Дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн боломж**

Дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, төлөвлөсөн үзүүлэлтүүдийн түвшинг хангахад хамгийн чухал нөлөөтэй зүйл нь санхүүгийн хувьд хангалттай эх үүсвэрээр тэтгэж өгөх явдал юм. Нөхцөл байдлын шинжилгээний хэсэгт бид 2020-иод оны эцэс хүртэл Монгол Улс гадаад өрийн хүнд дарамт, санхүүгийн хүнд нөхцөлд хэвээр байх тухай дурдсан.

Дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгохын тулд нэн тэргүүнд манай орны санхүүгийн тогтолцоог өөрчлөх хэрэгтэй. Улс орны мөнгө, санхүүгийн эрэлт хэрэгцээний 95 хувийг богино хугацаатай, өндөр хүүтэй арилжааны банкууд дангаараа хангаж, урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд хөрөнгийн зах зээл, даатгалийн байгууллагын оролцоо туйлын хангалтгүй байгаа өнөөгийн тогтолцоог эрс шинэчлэх шаардлагатай юм.

Төсвийн болон татварын бодлогод ч шинэчлэлт хийх хэрэгтэй. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, төсвийн алдагдал байнга нэмэгдэж, алдагдлаа ихэвчлэн гадаадын зээлээр нөхөж, гадаад өрийн хэмжээг өсгөсөөр байгааг анхаарах нь нэн чухал. Төсвийн сахилга батыг чанд сахиулах хариуцлагын тогтолцоог сайжруулах, нэгдсэн төсвийн зарлага эдийн засгийн өсөлтөөсөө давсан хурдтайгаар нэмэгдэж ирсэн зохисгүй байдлыг зогсоох нь зүйтэй.

Татварын хувь, хэмжээг оновчтой өөрчлөхөөс гадна татварын суурьт ихээхэн ач холбогдол өгвөл зохино. Гаалийн татварын ерөнхий түвшинг бусад орнуудынхтай харьцуулахад харьцангуй доогуур буюу 5 хувь, Нэмэгдсэн өртгийн албан татвар 10 хувь байгаа нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, импортын өрсөлдөөнөөс хамгаалахад дорвитой хөшүүрэг болж чадахгүй байна.

Манай оронд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа боловч улс орны хөгжил, хүн амын амьжиргаанд үзүүлэх нөлөө чамлалттай байна. Уул уурхайн салбараас улсын нэгдсэн төсөвт ордог татварын хувь хэмжээ бусад улс оронтой харьцуулахад дэндүү бага түвшинд байна. Ашигт малтмалын төрөл, хэмжээ, хүдрийн агуулга зэргээс хамаарч роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Австрали улс 30

хувь, Чили 30 хувь, Канад 25 хувь, Казахстан 15 хувь, Хятад 10 хувиар авч байна. Түүнээс гадна ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамжийг Австрали 5 хувь, Бразиль 15 хувь, Канад 25 хувь, Чили 15 хувь, Хятад 10 хувь, Энэтхэг 42 хувь, Казахстан 20 хувиар тогтоожээ. Ийнхүү уул уурхай, олборлох, боловсруулах салбар өндөр хөгжсөн дэлхийн улс орнууд роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өндөр тогтоох замаар улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн баталгааг хангаж, иргэдийнхээ аж амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулж байгааг анхаарах цаг болжээ.

Монгол Улсын уул уурхайн баялгаа түүхийгээр нь маш хямд экспортолж байгаа одоогийн загвараар цаашид явах боломжгүй болох нь тодорхой байгаа бөгөөд энэхүү байдлыг яаралтай өөрчлөх шаардлага тулгарч байна.

### 3. Санал

#### Дээрх дүгнэлтэд үндэслэн гаргасан саналууд:

- Ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын татварыг 30 хүртэл хувь болгон нэмэгдүүлэх;
- Хүдрийн агуулгаас хамаарч газрын төлбөрийг 30 хүртэл хувь болгон нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг хийх;
- Уул уурхайн барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн импортод 25 хүртэлх хувийн татвар ногдуулах;
- Уул уурхайн хаягдал овоолго ашиглаж олборлосон ашигт малтмалд 5 хувийн татвар ногдуулах;
- Ашигт малтмал ашиглалтаас төрд ногдох хувьцаа, ногдол ашгийн хувийг 25 хүртэл нэмэгдүүлэх;
- Ашигт малтмалын төрөл, хэмжээ, хүдрийн агуулга зэргээс хамаарч роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг 30 хүртэл нэмэгдүүлэх;
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамжийн хувийг 15 хүртэл нэмэгдүүлэх заалтуудыг холбогдох хуулиудад тусгах;
- Алтны экспортыг бүрэн зогсоож, алтны хуримтлалыг бий болгож, гадаад валютын нөөцийг бусад эх үүсвэрээр бүрдүүлэх хуулийн зохицуулалтыг хийх;
- Эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа төрийн бодлогын баримт бичгүүд, хууль эрх зүйн актуудыг хооронд нь уялдуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгомжтой бөгөөд тогтвортой эрх зүйн орчныг бий болгох;
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтыг нийтэд ил тод болгож, авилга, хээл хахуулийн сүлжээг устгах шаардлагатай гэж үзэж байна.

Ийнхүү, эрчимтэй хөгжиж байгаа уул уурхайн салбараас улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээг эрс нэмэгдүүлснээр хүрэн нүүрсний орд түшиглүүлэн цахилгаан станцуудыг барьж байгуулах дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломж гарна.

Нөгөө талаас, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлогыг явуулж, шаардлагатай

гэж үзсэн импортын барааны гаалийн татварыг 20 хүртэл хувиар өсгөх зэргээр дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээн дэх боломжийг бүрэн ашиглах шаардлагатай байна.

Хүнд аж үйлдвэрийн дээр нэр заасан үйлдвэрүүдийг барьж байгуулах хөрөнгийг хэрхэн санхүүжүүлэх талаар доор дурдсан санхүүжилтийн төрлийг ашиглах нь оновчтой гэж үзэж байна.

1. Боловсруулах үйлдвэрийн хөгжлийг дэмжихийн тулд үнэт цаасны зах дээрээс компаниуд хувьцаа, бонд гарган санхүүжилт олох;
2. Боловсруулах салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх;
3. Төсвийн зардлаар боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэхэд концессийг ашиглах, тэгэхдээ сонголтыг ил тод, өрсөлдөөнтэй хийх;
4. Боловсруулах үйлдвэр байгуулах болон хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг гадны орнуудын тодорхой төслөөр хэрэгжүүлдэг арга бий. Үүний тод жишээ бол манай оронд хэрэгжиж байгаа Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөрөнгөөр байгуулж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл ба зайлшгүй шаардлагатай нөхцөлд энэ аргыг хэрэглэх;
5. Гадаад зах зээлээс Засгийн газар бонд гаргах замаар мөнгө босгох аргыг үр өгөөжтэй хэрэглэх.

Монгол улсад санхүүжилтийн эдгээр төрлийн аль алиныг хэрэглэх боломжтой ч сонголтоо зөв хийх хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэе.

## НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016.
2. Гурван тулгуурт хөгжлийн бодлого, 2017.
3. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоол.
4. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол.
5. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол.
6. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол.
7. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2015.
8. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол.
9. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гарын авлага, Европын Холбоо, Монгол Улсын Сангийн яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, "Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал" төслийн багаас гаргасан. Улаанбаатар, 2016, 166.
10. Н.Итгэл, "Монгол Улсын үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын ерөнхий схем" Ц.Сүхбаатар, УБ, 2018.
11. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгах нь: Малайз улсын жишээ, туршлага.
12. ҮСХ, "Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо", 2017.
13. ҮСХ, "Монгол Улсын Статистикийн эмхэтгэл", 2016.
14. ҮСХ, "Монгол Улсын Статистикийн эмхэтгэл", 2017.
15. Үндэсний тооцооны нэгдсэн данснууд.
16. Сангийн яам Төсвийн хүрээний мэдэгдэл, 2018.
17. UNDP, UNEP, ILO, UNIDO, "UN Institute for Training and Research , Integrated Planning & Sustainable Development: Challenges and Opportunities", 2016.
18. World Bank, "GLOBAL ECONOMIC PROSPECTS", 2018.
19. IMF, World Economic Outlook, 2018.
20. ADB, Asian Development Outlook, 2018.
21. USDA, International Macroeconomic Data Set, 2018.
22. World Development indicators, 2002-2017.
23. ОУВС-ын цахим хуудас, [www.imf.org/external/datamapper/](http://www.imf.org/external/datamapper/).
24. ҮСХ-ны цахим хуудас, [www.1212.mn](http://www.1212.mn).





Үндэсний хөгжлийн газар  
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1  
Засгийн газрын II байр  
Утас: 976-51-263333  
[www.nda.gov.mn](http://www.nda.gov.mn)